

## Үндэсний тодорхойлсон хувь нэмэр болон Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний зорилтыг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ахиулахад дэмжлэг үзүүлэх (СКАЛА) хөтөлбөр



### “Малын тоо толгойн албан татварын тогтолцооны үнэлгээ” гэрээт ажлын эцсийн тайлан

**Гүйцэтгэгч:**

**МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН АШИГЛАГЧДЫН  
НЭГДСЭН ХОЛБОО**

**2023 оны 10 дугаар сар**

## Гарчиг

Нэг. Малын тоо толгойн албан татварын тухай хууль (МТТАТ-ын тухай хууль)-ийн хэрэгжилтийн үнэлгээ.....	7
Хоёр. GLEAM программ .....	7
ГЭРЭЭТ АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ .....	8
ӨМНӨХ ҮГ .....	9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ .....	11
ГЭРЭЭТ АЖЛЫН ЗОРИЛГО, ҮР ДҮН.....	11
ХОЁРДУГААР БҮЛЭГ .....	13
АРГА ЗҮЙ БА ХЭРЭГЛҮҮР .....	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ.....	17
МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ҮНЭЛГЭЭ.....	17
3.1 Малын тоо толгойн татварын хэрэгжилтийн үнэлгээ: үндэсний хэмжээнд.....	17
3.2 Алаг-Эрдэнэ сумын мал аж ахуйн салбарын тойм .....	19
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.....	23
МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ.....	23
4.1 Тодруулга.....	23
4.2 Холбогдох эх сурвалжийн тойм .....	23
ТАВДУГААР БҮЛЭГ .....	35
МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААРХ МАЛЧИД-ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ҮНЭЛЭМЖИЙН ТОЙМ: ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЖИШЭЭН ДЭЭР 35	
5.1 Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол .....	35
5.2 Алаг-Эрдэнэ сумын МТТАТ-ын орлогын төлөвлөлт, зарцуулалт .....	36
5.3 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд зөвлөх нь:.....	37
5.4 Сумын ИТХ-ын төлөөлөгчдөд зөвлөх нь: .....	39
5.5 Алаг-Эрдэнэ суманд явуулсан асуумжийн судалгааны дүн .....	39
ЗУРГААДУГААР БҮЛЭГ .....	50
МАЛЧИН ӨРХИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХУВААРЬ: .....	50
ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХООРОНДЫН АЖЛЫН ЗОХИЦУУЛАЛТ .....	50
ДОЛООДУГААР БҮЛЭГ .....	55
МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ (GLEAM)-ЫГ АШИГЛАН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ОДООГИЙН БАРИМТАЛЖ БҮЙ БОЛОН ИРЭЭДҮЙД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АРГА БАРИЛААС ҮҮДЭЛТЭЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ ҮНЭЛСЭН ДҮНГЭЭС.....	55
7.1 Хөдөө аж ахуйн салбарын хүлэмжийн хийн ялгарал .....	55
7.2 GLEAMi-г туршсан дүн.....	56

7.3 GLEAMi-ны туршилтын дүн .....	59
7.4 RECSOIL: тоо мэдээ цуглуулсан байдал .....	61
ДҮГНЭЛТ .....	63
ЗӨВЛӨМЖ.....	65

## Хүснэгт

Хүснэгт 1. Тогтолцооны түвшний үнэлгээний асуумжийн судалгаанд хамрагдсан малчдын тоо, багаар, алаг-эрдэнэ сум .....	15
Хүснэгт 2. Төрөл бүрийн малд ногдуулсан татварын хэмжээг аймгийн тоогоор түүвэрлэсэн дүн, малын төрлөөр.....	19
Хүснэгт 3. Мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр ҮТХН-ийн хүрээнд нэвтрүүлэх зорилт.....	27
Хүснэгт 4. Тогтолцооны түвшний үнэлгээ ба МТТАТ-ын хуульд хамаарал бүхий татварын элементүүд.....	29
Хүснэгт 5.Тогтолцооны түвшний үнэлгээ ба МТТАТ-ын тогтолцоо .....	30
Хүснэгт 6. МТТАТ-ын үнэлгээний хүрээ /үндэсний ба зорилтот сумын мэдээлэл, 2022 оны байдлаар/.....	32
Хүснэгт 7. Тогтолцооны үнэлгээний үзүүлэлтүүд (Алаг-Эрдэнэ сумын кэйсээс оруулав).....	<b>Error!</b>
<b>Bookmark not defined.</b>	
Хүснэгт 8. МТТАТ-ын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, 2023 оны байдлаар ..	37
Хүснэгт 9. ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлээр өгөх үндсэн зөвлөмжүүд.....	37
Хүснэгт 10. ИТХ-ын төлөөлөгчдөөс анхаарах асуудал, зөвлөмж.....	39
Хүснэгт 11. МТТАТ-ыг төлөх боломж: хариулагчдын хүйс ба өрхийн байдал .....	42
Хүснэгт 12. МТТАТ-ын төлөлт, 2021-2022, Алаг-Эрдэнэ сум, хувь .....	42
Хүснэгт 13. “Та яагаад татвараа төлөөгүй вэ?” асуултад өгсөн хариулт.....	46
Хүснэгт 14. Татвар төлөхөд хандах ханлага, татвар төлөгчдийн төрлөөр .....	49
Хүснэгт 15. Татварын орлогыг төлөвлөх, зарцуулахад татвар төлөгчдийн оролцоо (сумын ЗДТГ-ын албан тушаалтнаас өгсөн үнэлгээ).....	49
Хүснэгт 16. Малчин өрхийн хөдөлмөрийн хуваарь, гишүүдийн оролцоо, Алаг-Эрдэнэ сумын жишээ .....	51
Хүснэгт 17. бэлчээрийн маллагаатай үнээ 2023.....	57
Хүснэгт 18. бэлчээрийн ургац хадгалалт, сараар.....	58

## Тахирмаг

Тахирмаг 1. Татвар ногдуулалт, малын төрлөөр, аймгаар, 2021 оны дүнгээр .....	18
Тахирмаг 2. МТТАТ-ын хэмжээ, улсын дундаж, 2021 оны байдлаар, төгрөгөөр .....	19
Тахирмаг 3. Сумын нийт сүрэгт төрөл бүрийн малын эзлэх хувийн жин, 2018-2022.....	20
Тахирмаг 4. Төрөл бүрийн малын тооны өсөлт, 2018-2022 (2018 =100%).....	20
Тахирмаг 5. Алаг-Эрдэнэ сумын малын тооны өсөлтийн дүрслэл, хувь.....	21
Тахирмаг 6. Сумын малын тооны өөрчлөлт, 2018-2022 (2018=100%) ба 2027 онд хүрэх өсөлтийн хандлага .....	22
Тахирмаг 7. Урт хугацааны хувьсагч өөрчлөлтийн онолын дүрслэл.....	34

Тахирмаг 8. МТТАТ-ын тухай мэдээлэл хэр зэрэг авсан тухай хариулт, хувь.....	40
Тахирмаг 9. МТТАТ-ын мөнгөөр тогтоосон хэмжээний талаарх мэдлэг, хувь.....	41
Тахирмаг 10. МТТАТ-ын хэмжээний талаарх малчдын үнэлэмж, насаар, хувь.....	41
Тахирмаг 11. Мэдээлэл авсан байдал.....	43
Тахирмаг 12. МТТАТ төлдөг нийтлэг эх үүсвэр.....	45
Тахирмаг 13. Малын тоог цөөлөх эсэх, жендертэй холбоотой хандлага, хувь.....	47
Тахирмаг 14. Малын тоог цөөлөх эсэх, хувь.....	47
Тахирмаг 15. 2023 оны татварын мэдэгдлээ авсан эсэх, хувь.....	48
Тахирмаг 16. Өрхийн эрэгтэй гишүүн (нөхөр)-ий ажлын ачаалал.....	52
Тахирмаг 17. Гэрийн эзэгтэйн ажлын ачаалал.....	53
Тахирмаг 18. Өрхийн бусад гишүүдийн ажлын ачаалал.....	53
Тахирмаг 19. GLEAMi -програмын тооцоолол.....	57
Тахирмаг 20. Малын тоо буурсны үр дүнд хүлэмжийн хийг бууруулсан.....	60
Тахирмаг 21. GHG хүлэмжийн хийн ялгарал.....	61

## Тайланд ишлэл авсан бодлогын баримт бичгүүд

Доор дурдсан баримт бичгийг төслийн тайланд мэдээллийн үндсэн эх сурвалжаар ашигласнаас гадна ишлэл авсан болно.

### Хууль:

1. Монгол Улсын Иргэний хууль, <https://old.legalinfo.mn/law/details/15933>
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/, <https://lawforum.parliament.mn/draft/2/>
3. Малын тоо толгойн татварын тухай Монгол улсын хууль, <https://leap.unep.org/countries/mn/national-legislation/law-livestock-tax>
4. Газрын тухай Монгол Улсын хууль, [www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/land.pdf](http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/land.pdf)
5. Жендерийн тэгш байдлын тухай Монгол Улсын хууль, <https://evaw-global-database.unwomen.org/en/countries/asia/mongolia/2011/law-on-gender-equality>
6. Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль, [http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/environmental\\_protection.pdt](http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/environmental_protection.pdt)
7. Татварын ерөнхий тухай Монгол Улсын хууль, <https://resourcegovernance.org/sites/default/files/General%20Taxation%20Law.doc>
8. Малын генетик нөөцийн тухай Монгол Улсын хууль, <https://www.legalinfo.mn>
9. Засгийн газрын тухай Монгол Улсын хууль, [https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p\\_isn=49338&p\\_lang=en](https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p_isn=49338&p_lang=en)
10. Нэгдсэн төсвийн тухай Монгол Улсын хууль, <https://legalinfo.mn/mn/detail/12254>
11. Хууль тогтоомжийн тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын хууль, <https://legalinfo.mn/mn/detail/11119>

### Үндэсний хөтөлбөр:

1. Алсын хараа 2050, <https://legalinfo.mn/mn/detail/15406>
2. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), <https://policy.asiapacificenergy.org/node/4485>
3. Үндэсний дасан зохицох төлөвлөгөө, <https://www.en.ccrcc.mn/v/1h6057bg>
4. Жендерийн тэгш байдлын үндэсний хөтөлбөр, <https://evaw-global-database.unwomen.org/en/countries/asia/mongolia/2003/national-programme-on-gender-equality-2003-2015>
5. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025)

### Журам

1. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам, <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/law?c=136>

### Тайлан:

1. Mongolia's Biennial Update Report. <https://unfccc.int/documents/180667>
2. Third National Communication of Mongolia to UNFCCC

3. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр болон Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний зорилтыг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ахиулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр (СКАЛА) төсөл, эхлэлийн тайлан, <https://www.adaptation-undp.org/scala-mongolia-inception-workshop-report>

4. Малын тоо толгойн татварыг хэрэгжүүлэх зөвлөмж, МБАНХ

5. Gender Overview Mongolia: A Desk Study,  
<https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/SDC-Gender-%20Overview-Mongolia-%202014-EN.pdf>



## ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Монголын бэлчээр ашиглагчдын үндэсний нэгдсэн холбооноос гүйцэтгэсэн “Малын тоо толгойн татварын тогтолцооны түвшний үнэлгээ” гэрээт ажлын үр дүн, зөвлөмжийг энэхүү тайланд тусгав. Харилцан уялдаа бүхий гурван зорилгын хүрээнд дурдсан үнэлгээг гүйцэтгэсэн болно. Үүнд:

**Нэг. Малын тоо толгойн албан татварын тухай хууль (МТТАТ-ын тухай хууль)-ийн хэрэгжилтийн үнэлгээ.** Эдүгээ байгаа эх сурвалж, мэдээллээс үзвэл МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтэд зарим анхаарвал зохих асуудал байгаа юм. Татварын хэмжээг ихээхэн хэлбэлзэлтэй тогтоосон нь бэлчээрийн төлөв байдал, ашиглалтад тулгамдаж буй асуудлууд, малын тоо толгойн өсөлтийн талаар жинтэй дүгнэлт хийхэд сум, дүүргийн өөрөө удирдах байгууллага болон засаг захиргааны зүгээс үндэслэлтэй хандаж хараахан чадаагүйг харуулж байна. Аймгуудаар нэгтгэсэн дундаж үзүүлэлтээс харвал, малын тоо ихээр өсөж байгаа аймгуудын татварын хэмжээ бусад аймгийнхтай харьцуулахад доогуур байна. Үүнээс үзвэл уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлтэй нөхцөл байдлыг нь мал аж ахуй эрхлэгчдэд зөвөөр ойлгуулж чиглүүлэх, малын өсөлтийг бэлчээрийн даацад нийцүүлэхэд бодитой өөрчлөлт гарахад МТТАТ-ын тухай хууль одоогоор бодитой үр дүнд хүрэхэд хараахан эрт байна.

Гэрээт ажлын үндсэн судалгааг явуулахаар сонгосон Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын жишгээс төсөөлбөл, татвар ногдуулалт, төлөвлөлт, төвлөрүүлэлт янз бүр байна. Тухайлбал, 2021 онд татвар ногдуулалт, төвлөрүүлэлт сумын хэмжээнд амжилттай хэрэгжиж, татвар төлөгчдийн 98 гаруй хувь нь татвараа хугацаанд нь төлжээ. Харин дараачийн жил – 2022 онд энэ үзүүлэлт 46 хувь болж огцом буурсан байна. Татвар төлөгчдийн олонхын яриагаар татвар өгөжөөр тааруухан учраас дахин татвар өгөхөөс түдгэлзсэн байдалтай байна хэмээж байв.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд явуулсан санал асуулгад малчин 100 өрхийн төлөөлөл, түүний дотор 33 эмэгтэй хамрагдлаа. Малчдын өгсөн хариултаас үзвэл, татварын талаар мэдээлэл зохих хэмжээнд авсан, хуулийн заалтын талаар сайн мэддэг гэсэн хариултыг өглөө. Сумын ИТХ-аас тогтоосон малын тоо толгойн татварын хэмжээг нэлээд сайн мэддэг гэсэн дүн гарлаа.

Малчин өрхийн хувьд татвар төлөх эх үүсвэр нь цөөн, голчлон мал борлуулах, боломжтой зарим нь өрхийн үйлдвэрлэлийн орлогоос зарцуулдаг ажээ. Ийнхүү малын тоо толгойн албан татварын нөлөөгөөр мал борлуулалт өмнө оныхоос ийнхүү тодорхой хэмжээгээр нэмэгдэх нь гэсэн төсөөлөл авч болох юм. Тус сумын малын тоо сүүлийн 3 жилд бараг өсөөгүй, тогтвортой байгаа статистик үзүүлэлт үүний дам нотолгоо гэж хэлж болно. Малд нь татвар ногдуулах болсон хэдий ч малаа өсгөхөөс татгалзах эсэх талаар хараахан нэг мөр шийдээгүй байгаагаа судалгаанд хамрагдсан малчид илэрхийллээ.

**Хоёр. GLEAM программ:** Сүргийн нөхөн үйлдвэрлэл хэвийн явагдах хэмжээнд бүтцийг нь хадгалах, хүлэмжийн хийг бууруулах боломжийн хувьд оны эхний малын тоог 6 хувь цөөлөх хувилбар бусад хувилбар (5 ба 7 хувь цөөлөх)-тай харьцуулахад зохистой гэж

тогтоогдлоо. Үхэр сүргээр жишээлэн хийсэн тооцоогоор тоог нь 6 хувь цөөлөхөд хүлэмжийн хийн ялгаралт 0.2-0.9 хувь буурах боломжтой гэсэн үзүүлэлт гарав.

Бэлчээрийн мал аж ахуйн менежментийн нөхцөлд хүлэмжийн хийн хэмжээг үндэслэлтэй тооцоолохын тулд бэлчээрийн ногоо болон хагд өвсний ферментацийн явцад ялгарах хийн хэмжээг нарийн тогтоох шаардлагатай юм. Ийнхүү баталгаатай үзүүлэлт, мэдээлэлтэй болсноор бэлчээрийн мал аж ахуй бүхий бусад бүс нутагт хэрэглээнд нэвтрүүлэх бодит боломж бүрдэх болно.

**Гурав. RECSOIL** загварын мэдээллийн санг сумын хэмжээнд нэгдсэн байдлаар бүрдүүлэхийн тулд энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран үндэсний хэмжээний зөвлөгөөнийг зохион байгуулах шаардлагатай байна. Үүний үр дүнд ямар өгөгдөл хаана байгаа нь тодорхой болно. Үүний дараа мэргэжлийн баг мэдээлэл цуглуулж RECSOIL мэдээллийн санг бүрдүүлж болно. Хөрсний бүтцээс бусад физик шинж чанарын үзүүлэлтүүд одоогоор байгууллагуудын мэдээллийн санд байхгүй, RECSOIL загварт оруулахад хангалтгүй байна.

## ГЭРЭЭТ АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

**Гэрээт ажлын нэр: Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтийн тогтолцооны үнэлгээ**

**Захиалагч:** SCALA Монгол, НҮБ-ын ХХААБ, Хөгжлийн хөтөлбөр

**Гүйцэтгэгч:** Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо

**Хугацаа:** 2023 оны 4 дүгээр сараас 9 дүгээр сар



## ӨМНӨХ ҮГ

SCALA хөтөлбөр нь дасан зохицох чадавхыг бэхжүүлж хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, үндэсний дасан зохицох төлөвлөгөө (ҮДЗТ) болон үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-д тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд Африк, Ази, Латин Америкийн арван хоёр оронд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тогтвортой хөгжилд нь хувь нэмэр үзүүлдэг. “SCALA” хөтөлбөрийн тусгай зорилтын тухайд олон талын оролцоотойгоор Монгол Улсын ҮДЗТ ба ҮТХН-ийг газар ашиглалт, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжих уур амьсгалын өөрчлөлтийн бодит арга хэмжээ болгон төлөвшүүлэх зорилготой “SCALA Монгол” төслийг хэрэгжүүлж байна.

Дасан зохицох тэргүүлэх чиглэл, дасан зохицох болон даван туулах арга хэмжээний үр өгөөжийг тодорхойлох үндсэн хэрэгсэл болон уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээг үндэсний хэмжээнд чиглүүлэхэд туслах байгальд түшиглэсэн шийдлүүдийг тодорхойлох, төлөвлөх зорилгоор Үндэсний дасан зохицох төлөвлөгөө (ҮДЗТ)-г 2018 оноос эхлэн шинэчлэн боловсруулах шатандаа явж байна.

ҮДЗТ болон ҮТХН-д тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүд харилцан уялдаатай тул SCALA хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа дээрх хоёр баримт бичигтэй нийцтэй байхаар төлөвлөгдсөн. Ер нь бэлчээрийн менежментийг боловсронгуй болгож, малын тоог зохистой түвшинд барих нь Монгол Улсын хувьд дасан зохицох, даван туулах зорилтуудаа хэрэгжүүлэх, мөн нүүдэлчдийн уламжлалт өв соёлыг хадгалахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна<sup>1</sup>.

Шинэчлэн боловсруулж буй ҮДЗТ нь олон салбарыг хамарсан, дасан зохицох дунд, урт хугацааны төлөвлөлт, төсөвлөлтийг дэмжсэн, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хөгжлийн бодлогод тусгахад түлхэц өгөх баримт бичиг байна хэмээн үзэж байгаа. Уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын мэдээллийг боловсруулах, хуваалцах тогтолцоог бэхжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох санаачилгын тогтвортой санхүүжилтийн механизмыг хөгжүүлэхээр төлөвлөж байна<sup>2</sup>.

Мал аж ахуй, бэлчээрийн менежмент, газар тариалангийн дасан зохицох үйл ажиллагааг 2021 оны ҮДЗТ-ний үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлээр тогтоосон бөгөөд мал аж ахуйн хүрээнд дасан зохицох нэн тэргүүний зорилт нь экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэхэд чиглэдэг бол бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоог төлөвлөх, малын чанар, сүргийн бүтцийг сайжруулах, мал сүргийн болон өтөг бууцны менежментийг сайжруулах дасан зохицох тэргүүлэх чиглэл юм. Улсын хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 2010 онд тооцоолсон ердийн нөхцөлтэй харьцуулахад 22.7 хувиар бууруулах даван туулах зорилгыг ҮДЗТ-д тусгаад байна. Малын тоог зохицуулах, цөөлөх замаар хүлэмжийн хийг 5.28 сая тонн CO<sub>2</sub>-экв-аар бууруулж үндэсний зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилтыг хөдөө аж ахуйн салбар хэрэгжүүлнэ.

<sup>1</sup><https://www.fao.org/in-action/scala/news/news/news-detail/mongolia-prioritizes-adaptation-and-mitigation-goals-on-livestock-animal-husbandry-and-arable-farming/en>

<sup>2</sup><https://www.adaptation-undp.org/mongolia-achieves-milestone-national-adaptation-planning>

Малын тоо толгойн албан татвар бол 20 жилийн хүчингүй болгосон малын хөлийн татварыг орлох хувилбар юм. Шинэ хууль батлагдсан нь татварын тогтолцоог дахин нэвтрүүлэх замаар шинэчлэл өөрчлөлтийг бий болгох жишээ болно гэсэн найдвар тавьж байна. Улсын хэмжээнд МТТАТ-ын хүрээнд малын төрөл тус бүрд ногдуулах татварын хэмжээ аймаг, малын төрлөөр харилцан адилгүй байна. Энэ нь МТТАТ-ын хуулиар татварын хэмжээг тогтоох эрхийг сумын ИТХ-д олгосонтой холбоотой. Нэг аймгийн сумд гэхэд өөр өөрийн хөгжлийн стратегитай, ямар төрлийн малаа өсгөх, эсхүл өсөлтийг нь хязгаарлах вэ гэдэг дээр ялгаатай ханддагтай холбоотой бөгөөд энэ нь татварын хэмжээг аймаг бүр ялгаатай тогтоож байгаа гол асуудал юм.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### ГЭРЭЭТ АЖЛЫН ЗОРИЛГО, ҮР ДҮН

СКАЛА төслийн хүрээнд гүйцэтгэсэн тогтолцооны түвшний үнэлгээ нь газар ашиглалт, хөдөө аж ахуйн салбарт суурь өөрчлөлт авчрах уур амьсгалын арга хэмжээг хэрэгжүүлэх мэдээлэл нотолгоог бий болгоход чиглэж байна. МТТАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэх нэрийн дор сумын ИТХ-аас нэг загварын гэмээр, татвар төлөгчдийн оролцоо хангалтгүй шийдвэр гаргаж байгаа нөхцөлд бэлчээрт үзүүлж буй дарамт, ачааллыг бууруулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх арга замыг боловсронгуй болгоход энэхүү гэрээт ажил чиглэсэн болно.

Сумын өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагаас МТТАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэх шийдвэр гаргахдаа харгалзах бэлчээрийн ачааллыг зохистой түвшинд барих олон талын оролцоот зөвлөмж, удирдамж боловсруулах гол зорилготой. Өөрөөр хэлбэл МТТАТ-ын тухай хууль ямар шинэчлэл өөрчлөлт авчирсан, оролцоонд суурилсан хүртээмжтэй хэрэгжих боломжийг тодорхойлох хэмээн хэлж болно.

#### 1.1 Үр дүнд суурилсан зорилт

Гэрээний хугацаанд дараах гурван бүлэг зорилтыг хэрэгжүүлж үр дүн гаргахаар ажлын даалгаварт заасан болно.

**Үр дүн 1: Тогтолцооны түвшний үнэлгээ хийх.** Бэлчээрийн даацтай нийцүүлэн малын тоог зохицуулах зорилгоор нүүдлийн мал аж ахуйд зохистой өөрчлөлт авчрах уур амьсгалын арга хэмжээг хэрэгжүүлэх жендерийн мэдрэмжтэй нотолгоо бүхий суурь нөхцөлийг тодорхойлох, зөвлөхөд энэ үр дүн хамаарна.

1. Тогтолцооны түвшний үнэлгээ (ТТҮ)-д хамаарах үндэсний/бүсийн, орон нутгийн болон хандивлагчдын дэмжлэг бүхий үндэсний бодлого, эрх зүйн таатай орчин, идэвхтэй арга хэмжээний талаарх цаг үеийн мэдээллийн судалгаа хийх;

2. Үнэлгээ явуулахаар сонгосон суманд хээрийн судалгаа хийх;

3. Хувьсал өөрчлөлтийн бодлого, стратеги, хөгжлийн асуудлаар зөвлөлдөж, санал солилцох.

**Үр дүн 2:** Бэлчээр ашиглалтын менежментийн одоогийн ба төсөөлсөн практик ажиллагаатай уялдуулан хүлэмжийн хийн ялгарлыг GLEAM (Global Livestock Environmental Assessment Model) загвар ба RECSOIL программ ашиглан төслийн зорилтот сумын жишээн дээр тооцох

1. Хэрэглэгчийн гарын авлага болон веб хуудсуудыг ашиглан GLEAM болон RECSOIL программтай танилцаж, эзэмших,

2. Зорилтот сумын хүлэмжийн хийн ялгаруулалтыг GLEAM загвараар тооцоолж, судалгааны доорх үндсэн асуултад хариулт өгөх

а) хөдөө аж ахуй, газар ашиглалтын одоогийн үйл ажиллагаатай холбоотой хүлэмжийн хийн ялгарал/шингээлт,

- б) дасан зохицох, даван туулах хувилбарууд.  
3. Зорилтот сумын мэдээллийг RECSOIL загварт оруулж боловсруулах.

**Үр дүн 3:** Системийн түвшний үнэлгээний үр дүнг баталгаажуулах зорилгоор салбарын яамд, эрдэм шинжилгээний хүрээлэн, ялангуяа орон нутгийн жендерийн асуудал хариуцсан төлөөллүүд, сумын Засаг дарга нар болон иргэдийн төлөөлөл, малчдын нөхөрлөл/хоршоодыг оролцуулан олон талт (виртуал болон танхимын) уулзалт зохион байгуулах

1. Үндэсний түвшинд (танхимын) болон орон нутгийн түвшинд (виртуал) системийн түвшний үнэлгээг эцэслэн боловсруулахад санал, зөвлөмж авах зорилгоор цуврал семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах, үүнд;

а. Хэлэлцүүлэг, семинараас гарсан санал зөвлөмжийг тусгаж, “агроэкологи” аргачлалаар мал аж ахуйн нэгдсэн менежментийн системийн түвшний үнэлгээний эцсийн тайланг гаргах;

б. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, малчдаас “МТТАТ-ын тухай хууль”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд уур амьсгалын үйл ажиллагааг чиглүүлэх зөвлөмж, аргачлал боловсруулах.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### АРГА ЗҮЙ БА ХЭРЭГЛҮҮР

Гэрээт ажлын бэлтгэл арга хэмжээ нь даалгаварт заасан нийтлэг болон тодорхой асуудлыг хамарсан бөгөөд ажлын эхний болон эцсийн төлөвлөгөө боловсруулах ажил хийгдсэн болно.

#### 2.1 Ажлын төлөвлөгөө боловсруулах

Ажлын даалгаварт заасан удирдамж болон үйл ажиллагааны тодорхойлолтод үндэслэн ажлын төлөвлөгөөний эхний хувилбарыг гурван бүрэлдэхүүн хэсэгтэйгээр боловсруулав. Энэхүү эхний хувилбарт дараах үндсэн асуудлыг тусгасан болно. Үүнд:

- МТТАТ-ын тогтолцооны үнэлгээтэй холбоотой эрхзүйн ба үйл ажиллагааны эх сурвалжийн мэдээллийн тойм;
- GLEAM-тэй холбоотой болон Монгол орны нөхцөлд энэхүү хэрэглүүрийг нутагшуулах боломжийн талаарх мэдээлэл;
- RECSOIL загварыг үндэсний ба бүс нутгийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, сайжруулах гол зорилгоор ашиглах нотолгоо бүхий судалгаа, практик хэрэглээний мэдээллийн хайлт хийх;
- Жендерийн мэдрэмж бүхий татварын бодлого хэрэгжүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах олон улсын туршлагын тойм;
- Анхдагч ба хоёрдогч мэдээлэл цуглуулах, ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг сумын түвшинд зохион байгуулахад тохиромжтой аргачлал, арга зүй сонгох
- GLEAM-ийн интерактив матриксийн дизайн;
- RECSOIL-ийн загварын матриксийн дизайн.

SCALA хөтөлбөрийн үндэсний зохицуулагч болон тус хөтөлбөрийн олон улсын багаас явцын ба урьдчилсан тайлан болон гэрээт ажлын арга зүйн асуудлаар дараах санал зөвлөмж авч ажиллалаа. Үүнд:

- Аймаг, сумын хэмжээнд цуглуулах мэдээллийг default буюу суурь өгөгдөлд харгалзуулан тодорхойлох зорилгоор CLEAM and RECSOIL загварыг урьдчилан турших;
- GLEAM загварын үндсэн өгөгдөл, шалгуурыг тогтоох, шаардлагатай мэдээллийн олдцын асуудлаар үндэсний судлаачид ба GLEAM-I олон улсын багтай зөвлөлдөх;
- Урьдчилсан туршилтын дүнг ХХААБ-ын төсөл ба МААЭШХ-ийн ажилтан Уранхайчид танилцуулж зөвлөгөө авах;
- SCALA багтай хамтран CLEAM ба RECSOIL-ийн матрикст тохируулга хийх;
- CLEAM ба RECSOIL туршсан дүнгийн талаар салбарын яам, агентлаг, иргэний нийгмийн байгууллага, зорилтот сумын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.

Гэрээт ажлын эхлэлийн шатанд захиалагчаас өгсөн дээр дурдсан зөвлөмжийг гэрээт ажлын төлөвлөгөөнд бүрэн тусгаж /Төлөвлөгөөг бүрэн эхээр нь Хавсралт 1-д үзүүлэв/.

## 2.2 Тойм бэлтгэх болон хээрийн ажлын арга зүйг эцэслэн боловсруулах

**Мэдээлэл цуглуулах:** эх сурвалж ба хамрах хүрээ – үндэсний ба зорилтот сум (Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум)-тай шууд хамаарах мэдээлэл;

### ***Малчин зон ба малын тооны өөрчлөлт:***

- Малчин өрх, мал бүхий бусад этгээдийн тоог багаар гаргаж, баг тус бүрийн бэлчээрийн талбай (хэмжээ)-тай хэр зохицож байгааг сүүлийн 3 жилийн статистикт тулгуурлан үнэлэх;

- Мал аж ахуй, бэлчээр ашиглалтын анхан шатны нэгж болох БАХ-ийн тоо, үйл ажиллагааны байдалд хурдавчилсан үнэлгээ өгөх;

- Төрөл бүрийн малын тархалтыг байгаль-газарзүйн нөхцөл болон бэлчээрийн төлөв байдал (хэвшинж, ургамалжилт, даац)-тай хэр нийцтэй байгааг үнэлэх, тархалтыг зохицуулах боломжийн талаар зөвлөх.

- Сумын мал тооллогын сүүлийн 3-4 жилийн тоон мэдээллийг баг, малын төрлөөр задлан шинжлэх, ирэх 5 жилд мал сүргийн тоо толгойн өсөлтийн байдлыг төсөөлөх;

***Байгалийн бэлчээрийн мэдээлэл.*** Манай орны бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, фотомониторингийн тогтолцоог Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар зэрэг засгийн газрын агентлагууд эрхэлдэг бөгөөд дараах үзүүлэлтийг цуглуулж мэдээллийн санд оруулдаг. Үүнд:

- бэлчээрийн төлөв байдал;
- хөрсний морфологи, физик шинж чанар, хөрсний тогтворт байдал
- бэлчээр ашиглалтын нөлөө;
- бэлчээрийн бүтээмж;
- бэлчээрийн даац ба ачааллын зураг зэрэг болно.

### ***Жендерийн мэдрэмжтэй судалгаа ба сумын түвшний мэдээлэл цуглуулах:***

- зорилтот сум болон МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд жендер, нийгмийн оролцооны асуудлыг судлах.

- малчин өрхийн үйлдвэрлэл, боловсруулах ажиллагаанд оролцох жендерийн үүрэг, тэгш бус байдал, өрхийн ажлын хуваарь, түүний улирлын шинж чанарыг тодорхойлох;

- хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн зэрэг хүн ам зүйн өөрчлөлтийг тодорхойлох.

***МТТАТ-ын судалгаа.*** МТТАТ-ын тогтолцооны үнэлгээний мэдээлэл, нотлох баримтыг бүрдүүлэх зорилгоор нэлээд хэмжээний судалгаа, мэдээллийн дүн шинжилгээ хийлээ.

### **Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоосон малын тоо толгойн татварын хэмжээ:**

- татвар хураалт, татварын орлого бүрдүүлэлт;
- татвар төлөх хүсэмж, хандлага
- татварын орлогын зарцуулалт;
- татвараар өмнөх онд төвлөрүүлсэн орлогын ашиглалтын үр дүн, зорилтот сумын хөгжилд үзүүлсэн нөлөө;



**Мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам болон холбогдох бусад баримт бичгийн тойм.** Тойм бэлдэхэд SCALA төслийн тайлан болон бусад баримт бичиг. Дараах мэдээллийг цуглуулав. Үүнд:

о судалгаа, тойм бэлдэхэд үндэслэл болох үндсэн дүгнэлт, зөвлөмжүүд;

о давуу болон сул талууд (таатай ба тааламжгүй хүчин зүйлс, шалтгаан; давуутай болон зохимжгүй талууд);

**Асуумж** – Зорилтот сумын нийтлэг болон ялгаатай өвөрмөц байдлыг жишээлэн харуулах зорилгоор өргөн ашиглагддаг хээрийн судалгааны багц арга, бусад хоёрдогч мэдээлэл цуглуулах хэрэглүүр.

**Түүвэрлэлт** – Судалгаанд хамруулах түүврийн тооцоолол нь судалгааны баталгаа, бодит байдал шууд хамаарах үндсэн нөхцөлүүдийн нэг гэж үздэг. Асуумжид сонгох малчдын тоо бол гэрээт ажлын хувьд өндөр нарийвчлал, баталгаа бүхий тоон үр дүн гаргах гол нөхцөл юм. Биологи, эдийн засаг зэрэг ихэнх шинжлэх ухаанд баримталдаг асуумжийн төлөөлөл<sup>3</sup> 95 хувийн магадлалыг хангах тооцоогоор Алаг-Эрдэнэ сумын 797 малчин өрхөөс 100 өрхийг багийн эзлэх хувьд дүйлгэн санамсаргүй түүврийн аргаар сонгов. Малчдын тооноос гадна малын тооны бүлэглэл тус бүрийн нийт өрхөд эзлэх хувийг харгалзан бүлэглэл бүрээс сонгох өрхийн тоог тогтоосон болно.

Хүснэгт 1. Тогтолцооны түвшний үнэлгээний асуумжийн судалгаанд хамрагдсан малчдын тоо, багаар, алаг-эрдэнэ сум

Малын тооны бүлэг, өмчилж буй малын тоогоор	Баг					Өрхийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Сонговол зохих нийт өрхийн тоо
	Шувуут	Үжиг	Яргис	Цагаан бургас	Манхан			
0-100	42	37	30	22	65	196	<b>26</b>	
Эзлэх хувь	21	19	15	11	33	100	=	
Сонгох өрхийн тоо	<b>5</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>8</b>	=	=	<b>22</b>
100-200	34	48	27	37	36	182	<b>24</b>	
Эзлэх хувь	19	26	15	20	20	100	=	
Сонгох өрхийн тоо	4	6	3	5	5	=	=	<b>23</b>
201-500	63	91	36	40	31	261	<b>34</b>	
Эзлэх хувь	24	35	14	15	12	100	=	
Сонгох өрхийн тоо	8	11	5	5	4	=	=	<b>33</b>
501-800	30	30	8	7	2	77	<b>10</b>	
Эзлэх хувь	39	39	10	9	3	100	=	
Сонгох өрхийн тоо	4	4	1	1	0	=	=	<b>15</b>
800 and more	19	16	5	7	4	51	<b>7</b>	
Эзлэх хувь	37	31	10	14	8	100	=	
Сонгох өрхийн тоо	2	2	1	1	0	3	=	<b>9</b>
Бүгд	188	222	106	113	138	767		
Эзлэх хувь	25	29	14	15	18	100		
<b>Сонгох өрхийн тоо, багаар</b>	<b>24</b>	<b>28</b>	<b>13</b>	<b>14</b>	<b>18</b>	=	=	<b>100</b>

<sup>3</sup> <https://www.investopedia.com/terms/s/statistical-significance.asp>

**Хагас бүтэцжүүлсэн ярилцлагыг** тодорхой бүлгийн ашиг сонирхолтой холбоотой нийтлэг мэдээллийг цуглуулах юм уу асуумжаар цуглуулсан мэдээлэлд нэмэлт юм уу хавсарга чанартай асуудлыг тодруулах зорилгоор зохион байгууллаа. Энэхүү ярилцлагыг аль болох нээлттэй, асуудалдаа чиглэсэн, харилцан ярилцсан, оролцогчидтой байдлаар явууллаа.

**Хэрэглүүр ба мэдээлэлтэй боловсруулах дараах арга замыг ашиглав.** Үүнд:

- Судалгааны хэрэглүүрийг ажлын даалгаврын агуулга, арга зүйн шаардлагад нийцүүлэн боловсруулах (асуумж, ярилцлага гэх мэт);
- Судалгааны хэрэглүүрийг турших, тохируулах төлөвлөгөө боловсруулж, захиалагчаас өгсөн санал зөвлөмжийн дагуу эцэслэн, судалгаа болон туршилтыг явууллаа.
- Материал боловсруулалт - хоёрдогч болон хээрийн судалгааны тоо, мэдээлэл цуглуулсны дараа боловсруулж, дүн, өгөгдлийг эмхэтгэн эцсийн тайлангийн холбогдох бүлэг, хэсгүүдэд тусгав.
- Судалгааны материалыг боловсруулах, задлан шинжлэхэд SPSS (нийгмийн ухааны статистик шинжилгээний багц) болон CPro (тооллого, судалгааны материал боловсруулах программ) программыг ашиглалаа.
- Судалгааны хэрэглүүр (асуумж, ярилцлага)-ийг ажлын даалгаварт заасны дагуу боловсруулав.

### **2.3 Хэлэлцүүлэг, уулзалт**

Олон талын оролцоо бүхий үндэсний хэмжээний ба зорилтот сумын түвшний цуврал хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулахаар ажлын даалгаварт тусгагдсан болно. Энэ дагуу:

- Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын жишээн дээр МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн хээрийн судалгааны дүн хэлэлцэх, GLEAMi загварын урьдчилсан туршилтын үр дүнг танилцуулах арга хэмжээ зохион байгуулав.
- GLEAMi болон RECSOIL-ийн багтай он-лайн уулзалт хийж туршилтын урьдчилсан дүнг танилцуулах, цаашид хийх ажлын чиглэл, арга зүйн зөвлөгөө авлаа.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилт” сэдвээр 2023 оны 9 дүгээр сарын 08-д холбогдох яам, агентлаг, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, ТББ, МОБ-ийн төлөөлөл, судлаачдын оролцоотой өргөн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр гаргасан санал зөвлөмж авлаа.
- Гэрээт ажлын эцсийн үр дүн, зөвлөмжийг Хөвсгөл аймгийн бусад сумдтай хуваалцах он-лайн хэлэлцүүлгийг (SCALA Монгол болон Хөвсгөл аймгийн ИТХ, ЗДТГ-тай зөвшилцөж 10 сумыг сонгосон) Улаанбаатар хотод хийлээ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ҮНЭЛГЭЭ

Энэхүү тайланд засаг захиргааны янз бүрийн шатлалын татварын талаарх бодлого, стратеги, үйл ажиллагааны цаг үеийн мэдээллийн тоймоос гарсан зарчмын ач холбогдол бүхий гол дүгнэлтүүдээс гадна хээрийн судалгаа болон тусгай загвар, программыг туршсан дүнг тусгалаа.


“МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн тогтолцооны түвшний үнэлгээ” гэрээт ажлын даалгаварт тусгагдсан GLEAM, RECSOIL зэрэг орчин үеийн хэрэглүүрийг татварын тогтолцооны үнэлгээний хүрээнд туршихаар тусгасны дагуу: (i) үндэсний хэмжээний болон зорилтот сум (Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум)-ын бодит мэдээлэлд үндэслэн үнэлсэн МТТАТ-ын хэрэгжилттэй холбоотой асуудлууд; (ii) Монголын мал аж ахуйн менежментийн тогтолцоонд нэвтрүүлэх боломжтой хувилбарыг боловсруулах GLEAM-ийн туршилт, (iii) зорилтот сумын жишээн дээр RECSOIL-ийн туршилт явуулах гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар өөрчлөн төлөвлөсөн билээ. Гэрээт ажил гүйцэтгэгч байгууллагын нэг үүрэг бол малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтийн тогтолцоонд сүүлийн хоёр бүрэлдэхүүн хэсгийг хэрхэн тусгах талаар зөвлөх явдал байв.

Сангийн яам нь МТТАТ-тай холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх төрийн төв байгууллага юм. Энэ татварын хэмжээг тогтоох үйл ажиллагааг хэрхэн зохицуулж байгааг дүгнэлт өгөх, зөрүүтэй, ташаарсан асуудал гарч буй эсэхтэй танилцахын тулд албан эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн дүнг 3.1-д үзэж болно.

#### **3.1 Малын тоо толгойн татварын хэрэгжилтийн үнэлгээ: үндэсний хэмжээнд**

Төрөл бүрийн малыг: (i) бэлчээрийн тэжээлийн нөөцөд үзүүлэх нөлөөлөл, (ii) өрхийн амьжиргаанд үзүүлэх эдийн засгийн хувь нэмэр гэсэн хоёр үндсэн шинж чанараар үнэлдэг. Адуу, ямаанд хамгийн өндөр татвар ногдуулж, дараа нь үхэр оржээ. Ойт хээр, газар тариалангийн бүсийн аймгуудад ногдуулсан татвар баруун болон говийн бүсийн бусад аймгуудаас өндөр байна. Ерөнхийд нь харвал, манай орны газар тариалангийн бүс болох Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймагт татвар нэлээд өндөр тогтоогдсон байна. Говийн ба баруун аймгууд тэмээнд тэг татвар ногдуулсан болон татвараас чөлөөлжээ.

Тахирмаг 1. Татвар ногдуулалт, малын төрлөөр, аймгаар, 2021 оны дүнгээр




Эх сурвалж: <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=16360>

Ихэнх аймгийн хувьд ногдуулсан татварын хэмжээ 1000 төгрөгөөс даваагүй байна.

Төрөл бүрийн малыг байгаль орчинд үзүүлэх нөлөө, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалздаг гэж ойлгохоор байдал бүх аймагт ногдуулсан албан татварын хэмжээг тооцож гаргасан дундаж үзүүлэлтээс харагдаж байна. Малчдын орлогын нэлээд чухал эх үүсвэр болох ямаанд үхэр, хонийг бодвол өндөр татвар тогтоосон нь бэлчээрт халтай гэж үздэг хандлагыг тодорхой хэмжээгээр тооцсон байдал ажиглагдлаа. Эргэцүүлж үзвэл байгаль орчинд таагүй нөлөөлдөг учраас ямаанд ийнхүү өндөр татвар ногдуулах шалтгаан болсон гэж дүгнэлээ. Говийн аймгуудын хувьд малчдын амьжиргаанд ихээхэн хувь нэмэр оруулдаг тэмээнд тэг татвар ногдуулсан тохиолдол нэлээд байна.

ТАХИРМАГ 2. МТГАТ-ЫН ХЭМЖЭЭ, УЛСЫН ДУНДАЖ, 2021 ОНЫ БАЙДЛААР, ТӨГРӨГӨӨР



Эх сурвалж: Гэрээт ажлын багийн тооцоо, 2023

Хэдэн аймаг төрөл бүрийн малд хэдэн төгрөгийн татвар ногдуулсныг мөшгөвөл сонирхолтой дүр зураг харж болно. Адууны хувьд бүх аймгийн талаас илүү нь 800 ба түүнээс дээш төгрөг ногдуулжээ. Харин 21 аймгийн 49 хувь нь үхрээс 501-799 төгрөгийн татвар авахаар тогтоосон байхад хонинд ногдуулсан татвар 300-500 төгрөгийн хооронд хэлбэлзэж, ямаанаас 10 аймаг 501-799 төгрөгийн татвар авчээ.

ХҮСНЭГТ 2. ТӨРӨЛ БҮРИЙН МАЛД НОГДУУЛСАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ АЙМГИЙН ТООГООР ТҮҮВЭРЛЭСЭН ДҮН, МАЛЫН ТӨРЛӨӨР

Татварын хэмжээ, төгрөг	0	1-300	301-400	401-500	501-799	800-с дээш	Дүн
Адуу				3	6	12	21*
Үхэр		1		7	11	2	21*
Тэмээ	4	9	2	3		3	21*
Хонь		5	7	5	2	2	21*
Ямаа			3	5	10	3	21*

Эх сурвалж: 2021 оны мэдээллийг ашиглан гэрээт ажлы багийн хийсэн тооцоо, 2023

\* Аймгийн тоо

Тэмээнд гэхэд 9 аймаг 300 хүртэл төгрөгийн татвар ногдуулсан нь улсын хэмжээнд хамгийн доогуур үзүүлэлт болж байна.


### 3.2 Алаг-Эрдэнэ сумын мал аж ахуйн салбарын тойм

Манай орны нутаг дэвсгэрийн нэлээд хэсгийг эзэлдэг хээрийн бүс нутгийг төлөөлөх байдал, МТГАТ-ыг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан судлахад газар зүйн байршил, орон нутгийн хэтийн төлөвийн хувьд боломжтой хэмээн үзсэн учир гэрээт ажлын зорилтот сумаар Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумыг сонгосон болно. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны дөрөвдүгээр сарын 5-ны өдрийн “Байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт батлах тухай” 71 дүгээр тогтоолоор Алаг-Эрдэнэ сум нь уулархаг ойт хээрийн бүсэд хамаарна. Тиймээс тус сумын мал аж ахуйтай холбоотой аливаа асуудлыг тухайн бүс нутаг, цаг уур, орчны онцлогтой уялдаатай авч үзэх ёстой. Түүнчлэн тус сумын нутаг дэвсгэр Монгол орны уул хээр, ойт хээр, тал хээр гэсэн 3 гол дэд бүсийг дамнан байршдаг онцлог тогтоцтой юм.

Сүүлийн жилүүдэд явуулсан үнэлгээгээр малын тоо хэт өссөнөөс үүдэн Алаг-Эрдэнэ сумын бэлчээрийн нэлээд хэсэг нь дунд зэргийн доройтолд орсон байна. Иймд бэлчээрийн ачааллыг оновчтой болгох, малынхаа тоог өөрсдийн ашиглаж буй бэлчээрийн даацад нийцүүлэхэд малчдад нөлөөлөх, түлхэц өгөх хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх замаар доройтсон бэлчээрийг зохистой түвшинд нөхөн сэргээх явдал нэн тэргүүний тулгамдсан асуудал болоод байна.

Алаг-Эрдэнэ сумын 6-р баг буюу Хатгал тосгоныг оруулаад зургаан багт нутгийн үүлдрийн мал (үндсэндээ тэмээ цөөн, орон нутгийн амьжиргаанд тодорхой хувь нэмэр бараг оруулдаггүй) өсгөн үржүүлдэг эрхэлдэг бөгөөд энэ нь сумын эдийн засаг болон малчдын зоны амьжиргааны үндэс, нийгмийн сайн сайхны эх сурвалж юм. Алаг-Эрдэнэ сумын мал сүрэгт бог мал (хонь, ямаа) зонхилж байгаа бөгөөд үхэр, хонины өсөлттэй харьцуулбал ямааны эзлэх хувь буурах хандлагатай байна.


ТАХИРМАГ 3. СУМЫН НИЙТ МАЛД ТӨРӨЛ БҮРИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, 2018-2022



Эх сурвалж: 1212.mn, ҮСХ, 2023

ТАХИРМАГ 4. ТӨРӨЛ БҮРИЙН МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, 2018-2022 (2018=100%)






Эх сурвалж: Сумын статистикийг ашиглан гэрээт ажлын багийн хийсэн тооцоо, 2023


Хөвсгөл аймгийн бусад сумд болон бусад бүс нутгаас ялгаатай нь Алаг-Эрдэнэ сумын ямааны тоо сүүлийн 3 жилд буурч иржээ. Ийнхүү ямааны тоо буурсан явдал сумын малын тоо өсөлт багатай, харьцангуй тогтвортой байгаагийн гол хүчин зүйл болж байна..

ТАХИРМАГ 5. АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТИЙН ДҮРСЛЭЛ, ХУВЬ



Эх сурвалжгэрээт ажлын багийн тооцоо, 2023

ТАХИРМАГ 6. СУМЫН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, 2018-2022 (2018=100%) БА 2027 ОНД ХҮРЭХ ӨСӨЛТИЙН ХАНДЛАГА



Эх сурвалж: Гэрээт ажлын багийн тооцоо, 2023

Тэмдэглэл: тасархай улаан шугамаар сүүлийн 5 жилд буюу 2027 он хүртэл сумын малын тооны өөрчлөлтийн хандлагыг харуулав.

2019-2020 онд сумын малын тоо 7.3 хувь буурсан боловч малын тоог цаашид буурах хандлагатай барихад хангалттай нөлөө үзүүлж чадаагүй байна. Тиймээс малын тооны өсөлтийн хандлага нь шууд шулуун өгсөх чигтэй дүрслэгджээ. Мал сүргийн өсөлтийн сүүлийн 3 жилийн мэдээлэлд үндэслэн ирэх 5 жилийн прогнозыг гаргахад сумын мал жилд 0.4 хувиар өсөх магадлалтай байна. Энэ үзүүлэлт төрөл бүрийн малд татвар ногдуулахдаа дурдсан хандлагыг харгалзаж үзэх шаардлагатайг харуулж байна. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар аймгийн зүгээс нэлээд томоохон зорилт дэвшүүлсэн. Энэ баримт бичиг тусгагдсанаар Алаг-Эрдэнэ сумын хувьд 2020 онд 290.1 мянган толгой мал тоолуулсан нь 10 жилийн дараа буюу 2030 он гэхэд 58.0 мянган толгойгоор цөөрөх ажээ. Малыг төрлөөр нь ялгаж авч үзвэл, үхрийн тоо толгой +0.7 хувиар өсөхөөр төлөвлөгдсөн нь тийм ч өндөр үзүүлэлт биш юм. Харин эсрэгээр - хонь 19.4 хувь, ямаа - 37.3 хувь цөөрөх юм байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

# МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

## 4.1 Тодруулга

Зорилтот сумын ИТХ-аас МТТАТ-ыг хэрхэн ногдуулсан тухай авч үзэхийн өмнө татварын тогтолцоог хөгжүүлэхэд уламжилж ирсэн татварын бодлогын зарим зарчмуудын талаар зарим тодруулга өгөх нь зүйтэй гэж үзлээ. Янз бүрийн эх сурвалжууд татварын талаарх өөр өөр зарчим, бүтцийн санаа гаргаж, олон үндэслэлийг санал болгодог.

Малд ногдуулах албан татварын үндсэн зарчмууд:

- Татвар шударга, тэгш байх: Татвар бизнесийн үйл ажиллагааны хэлбэрээс үл хамааран шударга, тэгш байвал зохино.
- Тодорхой ба энгийн байх: Татварын журам, зохицуулга тодорхой бөгөөд ойлгомжтой байх, татвар төлөгчид ногдуулсан татвараа хэдийд хэрхэн төлөхөө мэддэг байх ёстой.
- Татвар төлөгдөхүйц, өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн чадварыг харгалзан тогтоосон байх ёстой.
- Татвар үр ашигтай байх ёстой. Гол санаа нь засгийн газрын бизнесийн болон удирдлагын зардлыг аль болох багасгах явдал юм.
- Үр нөлөөтэй, зохистой байх: ногдуулсан татварыг заасан хугацаанд төлөх, орлого, зарлагыг сайжруулж, олон нийтэд мэдээлдэг байвал татварыг ойлгоно.
- Уян хатан байдал: Татварын тогтолцоо нь өөрчлөгдөж буй бодлого, зохицуулалт, нөхцөл байдал өөрчлөгдөхөд аль болох тогтвортой байх, гэхдээ аль болох уян хатан, динамик байх.
- Сургалт, гэгээрүүлэх: татварын төлөгчдийн мэдлэг, ялангуяа татвар төлөгчийн үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулах, татварын орлогын тодорхой хувийг татвартай холбоотой арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах..

## 4.2 Холбогдох эх сурвалжийн тойм

### 4.2.1 Бодлогын баримт бичиг, үндэсний тайлан, зөвлөмж

Ямар эх сурвалж ашиглаж, ишлэл авч тойм бэлтгэхэд тодорхой болгохын тулд энэхүү тайланд эх сурвалжийн жагсаалтыг оруулсан болно. Зарим сэдэв, үр дүнг хэлэлцэх, гол асуудлын талаар хураангуйлсан мэдээлэл гаргах шаардлагын улмаас зарим баримт бичгийг доор тусгайлан дэлгэрүүлж авч үзсэн болно.

Өрхийн бүтээх ба боловсруулах ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү их ачаалалтай ажилладаг болохыг Швейцарын хөгжлийн агентлагийн жендерийн тайлангийн судалгааны

үр дүн<sup>4</sup> харуулж байна. Гэсэн хэдий ч шийдвэр гаргах, олон нийтийн оролцоо зэрэг мал аж ахуйн амьдралын бусад салбарт оруулсан үнэ цэнтэй хувь нэмэр, үүрэг нь ихэвчлэн дутуу үнэлэгддэг. Энэ байдлыг залруулахын тулд эмэгтэй, эрэгтэй малчдын өрхийн болон бусад ажилд оролцоог нь үнэлж, урамшуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах, уулзалт хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг сурталчилгааны ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Түүнчлэн сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран ажиллах нь эмэгтэйчүүдийн оруулсан хувь нэмрийг онцолж, өрхийн мал аж ахуйн үйл ажиллагаанд тэднийг илүү тэгш хамруулахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засгийн газар жендерийн тэгш байдлыг хангах, ялангуяа эрэгтэй, эмэгтэй хүний газрын эрхийг сайжруулах, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхийн тулд газар өмчлөх үйл явцыг дэмжихэд онцгой ач холбогдол өгч байна. Дээр дурдсан хууль батлагдсанаас хойш эмэгтэйчүүдийн газар өмчлөх эрхийг хамгаалахад багагүй ололт амжилтад хүрчээ<sup>5</sup>.

**А. Жендер ба малын тоо толгойн албан татвар.** Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хүүхдээ асран хүмүүжүүлэх бараг албан ёсны гэж хэлж болох үүрэг хүлээсэн өрхийн тэргүүн, эхнэр хоёрын аль нэг нь өмнөх оны есдүгээр сараас дараа жилийн зургаадугаар сар хүртэл 8 сар шахам тусдаа байх тун төвөгтэй асуудал тулгардаг. Гар утас зэрэг харилцааны хэрэгслээр тодорхой асуудлаар тэд хоорондоо ярилцаж, хэлэлцэж, зөвшилцөх боломжтой ч энэ нь нүүр тулан ярилцахтай харьцуулшгүй өөр үл хүссэн үр дүнд хүргэж болзошгүй юм. Өрхийн түвшинд зайлшгүй зөвшилцөх, зөв шийдэлд хүрэх, заавал шийдвэрлэх нэг асуудал бол МТТАТ-ыг ямар эх үүсвэрээр, хэрхэн төлөх вэ гэдэг асуудал юм.

Олон судалгаанд нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийн тухай асуудлыг тусгах хандлагатай байдаг ч жендерийн асуудлыг төдийлөн чухалд тооцдоггүй. Учир нь тэд эмэгтэйчүүд, нийгэм гүйцэтгэх илүү олон үүрэг чухамдаа тэдний нуруун дээр ирдэг тул жендерийн асуудлыг сөхөж ярихаас бэргэх явдал бий. Перу улсад хийсэн судалгаагаар бага сургуулийн хүүхдүүд ээжтэйгээ амьдардаг нь эмэгтэйчүүдийг нийгэм, гэр ахуйн олон чухал ажлаас холдуулж, шийдвэр гаргахад биеэр оролцох, нөлөөлөх чадварыг нь хязгаарладаг болохыг тогтоожээ. “Монгол Улсын санхүүгийн салбарт жендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн аргыг нэвтрүүлэх нь” төслийн тайланд үүнтэй төстэй тохиолдлыг дурджээ.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цаг уурын цочролыг даван туулах, урт хугацааны өөрчлөлтөд дасан зохицох чадвар өөр өөр байдаг. Жишээ нь:

- уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон зохистой хариу арга хэмжээний мэдээлэл авах боломж эмэгтэйчүүдэд харьцангуй багатай байдаг
- мэдээлэл олж авах, ашиглах, сургалт, боловсролын бусад үйл ажиллагаанд хамрагдах нь сул байдгаас малчин эмэгтэйчүүдээс сайн туршлага, технологийг сурвалжлан олох, эзэмших чадавхын түвшин бага;

<sup>4</sup> <https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/SDC-Gender-%20Overview-Mongolia-%202014-EN.pdf>

<sup>5</sup> <https://faolex.fao.org/docs/pdf/mon42187.pdf>

- эмэгтэйчүүдийн өмчийн мал, эзэмшиж буй машин техник зэрэг үр өгөөжтэй чухал хөрөнгө бага байна. Энэ нь тэдний хувьд өрхийн түвшинд хөдөлмөр, санхүүгийн шийдвэр гаргахад оролцох, МТГАТ төлөх боломжийн талаар шийдвэр гаргах гэх мэтээр хувь нэмрээ оруулах чадварыг хязгаарладаг;

- эмэгтэйчүүд гэр орны болон гадаах ажлын аль алинд нь оролцдог, олон давхардсан ажлыг хийдэг учраас ажлын ачаалал ихтэй байдаг, тиймээс ажил, амьдралын чухал үйл үйл явдлын талаар тогтмол мэдээлэл, мэдлэг олж авах, өрхийн идэвхтэй, мэдлэгтэй гишүүн болоход саад болдог тал бий.

Дээрх нөхцөл байдал болон жендерийн бусад асуудлыг харгалзан үзэж, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглож, төрийн албаны янз бүрийн түвшний улс төрийн албан тушаал, захиргааны удирдах албан тушаалд жендерийн харьцааны зорилтот түвшинг тогтоосон “Жендерийн тэгш байдлын тухай хууль”-ийг (2011)<sup>6</sup> мөрдөж байна. Энэ хуульд МТГАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэхэд түлхэц болохуйц хоёр үндсэн асуудлыг тодорхойлжээ.

4.1.2. "жендерийн эрх тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ. Эмэгтэйчүүдийн хувьд энэ заалт өөрийн эрхийг ойлгож мэдэх, бодитой хэрэгжүүлэхэд гэгээрүүлэх ач холбогдолтой юм.

4.1.3. "жендерийн хэвшмэл үзэл" гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг хэлнэ. Энэ бол МТГАТ-тай холбоотой аливаа арга хэмжээнд эмэгтэйчүүдийг түлхүү оролцуулж, тэдний дуу хоолойг сонсож байхын чухлыг энэхүү татварыг хэрэгжүүлэхэд оролцдог албан тушаалтнуудаас зайлшгүй баримтлах заалт юм.

**Б. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025).** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А-94 дүгээр тушаалаар батлагдсан энэхүү бодлого нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналтаар дэмжихэд чиглэнэ.

Салбарын жендерийн бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

Зорилт 1. Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендерийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх;

*Хүрэх үр дүн: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээг жендерийн мэдрэмжтэй хийх арга хэрэгсэл, мэдлэг чадавх бүрдэж, жендерийн тэгш байдлыг хангах тогтолцоо хөгжинө.*

Зорилт 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжин жендерийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэх;

*Хүрэх үр дүн: Салбарын ажиллагсдын ажлын орчин нөхцөл, тэдэнд чиглэсэн төрийн үйлчилгээ ба хүний нөөц бэлтгэх тогтолцооны жендерийн мэдрэмж сайжирч,*

<sup>6</sup><https://legalinfo.mn/mn/detail/253>

эмэгтэй, эрэгтэй хүмүүс салбарын хөгжилд хувь нэмэр оруулах боломж, чадавх сайжирна.

Зорилт 3. Үндэсний ба олон улсын түвшин дэх жендерийн түншлэл, хамтын ажиллагаагаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих.

*Хүрэх үр дүн: ХХААХҮ-ийн салбарт тулгамдаж буй жендерийн асуудлыг шийдэх салбар дундын зохицуулалт, түншлэл хамтын ажиллагаа үндэсний болон орон нутгийн түвшинд сайжирч, олон улсын түвшинд салбарын жендерийн асуудлаар манлайлан ажиллах чадавх бүрдэнэ.*

**В. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр.** Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Засгийн газраас 2017 онд баталсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь ТХЗ-д хүрэхэд шаардагдах жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийн үйл явцад дэмжлэг үзүүлэхэд оршино. Тогтолцооны түвшний үнэлгээтэй холбоотой хөтөлбөрийн гол зорилтууд:

Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;

Зорилт 3. Жендерийн гүйцэтгэх үүрэг, оролцооны талаар жендерийн боловсролыг бүх нийтэд олгох нөлөөллийн ажлыг өрнүүлэх;

Зорилт 6. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний туршлага, боломжийг дээшлүүлэх.

Жендерийн тэгш байдал нь Тогтвортой хөгжлийн хөтөлбөр - 2030-ийн ерөнхий зорилго бөгөөд бүх зорилго, зорилт нь жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн чадвараас хамаарна гэж заасан байдаг<sup>7</sup>. Шийдвэр гаргагчид, шинжээчид, иргэний нийгмийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл зэрэг оролцогч талуудтай яриа хэлэлцүүлэг өрнүүлж, эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжуулах, шийдвэр гаргахад тэдний байр суурийг сайжруулах, өрхийн хөрөнгө, нөөцийг бий болгох, удирдахад бодит арга хэмжээний талаар тохиролцох замаар жендерийн тэгш байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

**Г. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН).** Дараах үндсэн зорилтыг хангах замаар хөдөө аж ахуйн хүлэмжийн хийн ялгарлыг 5,283.3 Gg CO<sub>2</sub>-eq хэмжээгээр бууруулахаар ҮТХН-т тусгажээ.

- Малын тоог хязгаарлах, бууруулах,
- Малын өтөг шивхийн менежментийг сайжруулах

Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд орон нутгийн санаачилга, хариуцлагыг дээшлүүлэхэд бодлого-санхүүжилтийн хэрэглүүр болох МТТАТ-ыг оновчтой ашиглах боломж нээгдлээ.

<sup>7</sup><https://www.undp.org/bosnia-herzegovina/news/economic-empowerment-women-through-inclusive-political-dialogue>



Хүснэгт 3. Мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр ҮТХН-ийн хүрээнд нэвтрүүлэх зорилт

<b>Зорилт:</b>	<b>Хүрэх үр дүн:</b>	<b>Боломжит арга хэмжээ:</b>
<p>Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг бууруулах замаар салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх</p>	<p><b>Хүрэх үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрх зүйн орчин, бэлчээрийн менежментийг сайжруулах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах;</li> <li>• Малын тэжээлийн тариалалт, усан хангамжийг нэмэгдүүлэх замаар бэлчээрийг тогтвортой ашиглах;</li> <li>• Ган, зудын гамшгаас урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох.</li> </ul>	<p><b>Боломжит арга хэмжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Малын тоо толгойн албан татварын хуульд заасан арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөний биелэлтийг хангах</li> <li>• МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн тогтолцооны үнэлгээний хүрээнд туршсан CLEAMi, RECSOIL загварыг хүлэмжийн хийн ялгарлын хяналтад ашиглах</li> <li>• Малын бууц, шивхийг компостжуулж, органик бордоо болгон органик үйлдвэрлэлд хэрэглэх</li> <li>• малын тэжээл тариалах, хадлан бэлтгэхэд усалгааны боломжтой эх үүсвэрийг өргөн ашиглах,</li> </ul>

**Д. Орон нутгийн хөгжлийн сан.** Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл бөгөөд 2011 онд батлагдсан Төсвийн тухай хуульд тусгалаа олсон. Тухайн орон нутгийн иргэд нь өөрсдөө тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөлд оролцох боломжтой болох юм. ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Татварын тухай хуулийн 60.2.8-д заасны дагуу<sup>8</sup> МТТАТ-ын орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

#### 4.2.2 Малын тоо толгойн татварын тогтолцооны үнэлгээ

Энэхүү тайланд дурдсанчлан тогтолцооны үнэлгээ нь тухайн тогтолцооны давуу болон сул талуудыг тодорхойлох цогц зорилготой байдаг. Үүнтэй холбогдуулан МТТАТ-ын тухай хуулийн үндсэн зарчмууд болон түүний давуу болон сул талуудыг тогтолцооны түвшний үнэлгээний агуулга, аргачлалаар үнэлэв.

<sup>8</sup> <https://legalinfo.mn/mn/detail/12254>

Нэгдмэл цогц, харилцан үйлчилдэг хэсгүүдийн багц хэмээн тогтолцоог тодорхойлж болно. Тогтолцоо нь энгийн эсхүл нийлмэл хэлбэртэй байж болно<sup>9</sup>. Зүйрлэвэл, өвсний хадуур гэхэд хэд хэдэн хэсгийг хооронд нь механикаар холбосон энгийн тогтолцоо юм. Харин татвар бол эрх зүй, зохион байгуулалтын олон асуудлууд харилцан уялдаагаар холбогдсон олон талыг хамаарсан тогтолцоо юм. МТТАТ нь иймээс орон нутгийн мал аж ахуйд суурилсан эдийн засаг, малчин зоны амьжиргаанд гинжин хэлхээ өөрчлөлтийг нөхцөлдүүлэх юм уу авчирч болно. МТТАТ-ын тогтолцоо нь түүний бүрдэл салангид элементүүдээс илүүтэй цогц үйл ажиллагаа, хамааралтай байдаг. Энэ талаас нь харвал, энэ татвар мал аж ахуйгаас олж буй ашиг шим, ашигт ажиллагаанаас бус, харин малын тооноос ихээхэн шалтгаалдаг.

Хууль бол түүнийг бий болгох/бүрдүүлэх бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг тул түүнийг хэрэглэхэд хөнгөвчилж өгдөг хүчин зүйл, тэдгээрт хамаарах чиглэл гэж бий. Татварын хуулийн эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг бүрдүүлдэг талууд татварын бүрэлдэхүүн хэсэг нь юм. Мөн татвар ногдуулах үндэслэл, хариуцах байгууллага, төлөх татварын хэмжээ болон бусад олон зүйлийг тусгана. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөнөөр татварын эрх зүйн хэсгүүд нь татвар төлөлтийн тогтолцоог хөнгөвчлөхийн тулд юу, яагаад, хаана, хэрхэн, хэзээ хэрэгжиж байгааг нарийвчлан тусгасан байх ёстой.

#### ШИГТГЭЭ 1. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТОВЧ

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг УИХ-аар 2020 оны 11 дүгээр сард баталсан, 2021 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн болно. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малчин, мал бүхий этгээд татвар төлөгч байна.

Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна. Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно.

Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох зорилгоор холбогдох төрийн байгууллага, эрх бүхий этгээд мал тооллого, бүртгэлийн мэдээлэл, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.8-д заасан сангийн мэдээллийг татварын албанд гаргаж өгнө.

Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө. Албан татвар төлөгч нь албан татварыг урьдчилан төлж болно.

Энэ хуульд хүлэмжийн хийг бууруулахад хувь нэмэр оруулах талаар тодорхой заалт тусгагдаагүй болно.

<sup>9</sup><https://abdulapopoola.com/2018/06/26/chaotic-complex-and-complicated-systems-understanding-complexity-a-system-for-categorizing-problems-and-solutions/>

МТТАТ-ын тухай хуулийн албан бус орчуулгыг тайланд хавсаргасан болно /Хавсралт 6 – зөвхөн англи хэл дээр бичсэн тайланд хавсаргасан/ ба энэ тайланд уг хуулийн монгол эхийг дурдсан хавсралтад орууллаа.

ХҮСНЭГТ 4. ТОГТОЛЦООНЫ ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ БА МТТАТ-ЫН ХУУЛЬД ХАМААРАЛ БҮХИЙ ТАТВАРЫН ЭЛЕМЕНТҮҮД

Татварын элементүүд	Тогтолцооны түвшний үнэлгээ ба МТТАТ-ын хуульд хамаарах байдал
<p><b>Татварын хэмжээ</b> нь татвар төлөгч бүрийн татвар төлөх ёстой татварын хэмжээг тодорхойлдог. Татварын хэмжээ нь тодорхой бөгөөд хөдөлбөргүй байх ёстой. Татварын тогтолцоон дахь луйвар, авлига хээл хахуулийг бууруулах, шударга, ойлгомжтой байдлыг сайжруулахын тулд хэдий хэмжээний мөнгөөр төлөх ёстойг хэмжээ нь харуулах ёстой. Гэхдээ татвар төлөгчийн хувьд төлөх боломжтой байх шаардлага тавигдана.</p>	<p>Бэлчээрийн ачааллыг зохистой түвшинд барих тулгамдсан асуудлыг татварын хүрээнд авч үзвэл бэлчээрийн бүтээмж болон тэжээлийн нөөц буурч, ачаалал хэтрэн доройтсон учраас бэлчээрийг сэргээх явдал юм. Хуульд заасан 12 төрлийн үйл ажиллагааг дэмжихийн тулд жил бүр ихээхэн хэмжээний төсвийн эх үүсвэр бүрдүүлэх шаардлагатай. Жишээ нь, бэлчээр сайжруулахад "хөрөнгө оруулалт" хийхэд хангалттай орлого олоход татварыг нэг маягаар, өндөр хэлбэлзэлтэй тогтоож байгаа нь хангалттай бус байх үндэслэлтэй. Зөв, зохистой менежментээр бэлчээр сайжруулах, бэлчээрийн ачааллын хэтрэлтийг бууруулахад зориулж МТТАТ-ын орлогыг 30 хүртэл хувийг хуваарилахыг санал болгож буй тохиолдол цөөнгүй байна.</p>
<p><b>Татвар төлөлт:</b> Ногдуулсан татварыг хэрхэн төлөх, ямар бичиг баримт бүрдүүлэх, ямар хугацаанд төлөх ёстойг харуулдаг татвар төлөх зохицуулалтаар тогтооно. Татвар төлөлтийг ийнхүү зохицуулснаар татвар төлөгчөөс үүргээ биелүүлэхэд дөхөм өгдөг талтай. хөнгөвчилдөг. Мөн татварын албанаас шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, эмхлэх, боловсруулалт хийхэд тустай.</p>	<p>МТТАТ-рыг төлөхтэй холбоотой нэг асуудал бол татварын хугацаа юм. МТТАТ-ын тухай хуульд заасны дагуу татварыг 7-р сарын дундуур, 12-р сарын сүүлээр төлнө. Энэхүү журам нь мал аж ахуй, газар ашиглалтын улирлын чанартай нийцэхгүй байна. Энэ хууль нь татвар хураалтын ердийн зохицуулалтыг хуулбарлан авч бэлчээрийн мал аж ахуйн онцлогийг зориудаар орхигдуулсан гэхэд болно. Хугацаа их алддаг, төлөхдөө удаашрал, зөрчил ихээр гаргаж байгаа нь мал аж ахуй, бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанд орлогын зөвхөн хагасыг (12-р сард цуглуулсан) зориулах зохисгүй байдалд хүргэж байна.</p>
<p><b>Татварын суурь:</b> Татварын суурь бол хэдий хэмжээний татвар ногдуулах эх үүсвэр байгааг тодорхойлохтой холбоотой. Энэ нь хувь хүний эдийн засгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгө, орлого, хэрэглээг хамардаг, татварын үр ашигтай, эрх тэгш бааз суурийг бий болгоход чиглэдэг.</p>	<p>МТТАТ-ийн суурь нь малчин өрх, мал бүхий этгээдийн өмчийн малыг хамарсан, зөвхөн нэг төрлийн хөрөнгө (мал)-д татвар ногдуулах нийтлэг зохицуулалттай юм. Малын тоо толгой өсөх нь татвар орлогын нийт хэмжээг нэмэгдүүлэх магадлалтай боловч татварын дарамт улам нэмэгдэнэ гэдгийг анхаарах хэрэгтэй.</p>
<p>Татвар төлөгч <b>татварын мэдэгдэл</b> хүлээн авснаар төлбөл зохих татварын хэмжээ, татварын хариуцлагын талаар бодитой албан ёсны мэдээлэл, ойлголт авдаг.</p>	<p>Сумын Засаг даргын Тамгын газарт татвар хариуцсан нэг албан тушаалтантай, нөгөө талаас татвар төлөгчид сумын төвөөс алслагдсан, байршил сийрэг учраас ажлын ачаалал ихтэйгээс гадна малчид сумын албанд очиж татварын мэдэгдэлтэй танилцаж, хүлээн авахад бэрхшээл учирдаг. Ихэнх тохиолдолд багийн засаг дарга нар болон бусад хүмүүс мэдэгдлийг хүргэдэг бөгөөд энэ нь МТТАТ болон холбогдох журмын талаар татвар төлөгчид бодитой мэдлэгтэй болоход зарим талаар саад болж байна.</p>

<p><b>Малын тоонд уяж шууд тооцох</b> аргаар ногдуулбал зохих татварын хэмжээг тооцож байгаа.</p>	<p>Малын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь татвар төлөгчдийн дунд татварын хэмжээ жил ирэх тусам нэмэгдлээ гэсэн буруу ойлголт төрүүлж байна. Малчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд мал сүргийнхээ тоо толгой, төрөл зүйлийн бүтэц, хүйс, насны харьцааны бодит өөрчлөлтийг жил бүр зөв тооцдоггүй байна. Энэ бүх өөрчлөлтийг мэдэхгүй байгаа тул малчид татвараа мэдэгдлээр хэмжих хандлагатай байдаг. Малынхаа тоо толгой, бэлчээрээ анхаарлын гадна орхиж, мэдэгдэл дээрх тоог хардаг энэ байдал МТТАТ бэлчээр ашиглалтын эрчим, ачааллыг бууруулах, цаашилбал сүргийн менежментэд зөв нөлөөлж байгаа эсэхийг тодорхойгүй болгож байна.</p>
<p><b>МТТАТ-ын шинжлэх ухааны үндэслэл,</b> татварын хэмжээг тогтвортой барих, пропорциональ жишиг давамгайлж байгаа гол асуудлуудыг эргэж нягтлах, шинэчлэх шаардлагатай байна.</p>	<p>Хууль, түүнтэй холбоотой зохицуулалтад малын тоо толгойд татвар ногдуулсны шинжлэх ухааны үндэслэл, татварын орлогыг хэрхэн зарцуулах талаар тодорхой тайлбар, тодруулга дутагдаж байна. Малын тоо болон сүргийн бүтцийн болон бусад өөрчлөлтийг дагаад өмнөх жилүүдэд тогтоосон хэмжээг шинэчлэх шаардлагатай болно. Энэ нь малчин өрх-татвар төлөгчдийн дунд татвар нэмэгдэж байна гэсэн эргэлзээ төрүүлж байна. Тухайлсан төрлийн мал, ялангуяа ямаа, адуу зэрэг өндөр татвартай малын тоо нэмэгдэхэд энэ байдал илүү тод мэдрэгдэж байна.</p>
<p>Нэг талаас, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлд үндэслэн татварын баазыг тооцоолох арга зүйн хандлага нь <b>тооцоолол хөдөлбөргүй, илүү бодитой</b> байхыг шаарддаг.</p>	<p>Жил бүрийн мал тооллого хэр үнэн зөв явагддаг, баталгаатай тоо мэдээлэл гардаг эсэхэд эргэлзмээр зүйл яригддаг. Малын тоо ташаа бол татварын <b>тооцоолол хөдөлбөргүй, үнэн бодит</b> байдал, түүний хэмжээтэй холбогдох, шууд нөлөөлөх асуудал юм. Малаа зөв тоолуулсан өрх малаа дарсан этгээдээс илүү мөнгө төлөхөд туйлын зохисгүй байдал мал тооллогоос үүдэж болзошгүй тул малын тооноос гадна ашиглаж буй бэлчээрийн хэмжээ, бүтээмж зэрэг үзүүлэлтүүдийг давхар харгалзах, хяналтдаа авах нь зүйтэй.</p>

Хүснэгт 5. Тогтолцооны түвшний үнэлгээ ба МТТАТ-ын тогтолцоо

Татварын тогтолцооны нийтлэг элементүүд	Малын тоо толгойн албан татвар		Тодруулга
	Давуу талууд	Сул талууд	
<p>Татвар тогтоох үндэслэл, шаардлага</p>	<p>Бусад татвараас ялгаатай нь энэ хуулиар мал бүхий этгээдэд татвар ногдуулах ганц зорилготой.</p>	<p>Энэ хуулийг яагаад батлах шаардлагатай болсныг нотлох үндэслэлийг тайлбарлахын тулд үндэслэл сайтар боловсруулсан журам гаргах шаардлагатай байна.</p>	<p>2003 онд хүчингүй болгосон малын хөлийн татвартай МТТАТ-ыг хольж ойлгох хандлага төлөгчдийн дотор ажиглагдаж байна. Чухамдаа малд татвар ногдуулсан явдал хуулийн үндэслэл, шаардлагыг бүдгэрүүлж ойлгомжгүй байдлыг бий болгож байна</p>
<p>Татварыг төлөх чадвартай нь уялдаатай тогтоох зарчим</p>		<p>✓Татварыг төлөх чадвартай уялдуулах зарчмыг хуульд заагаагүй ✓Хэвтээ ба босоо чиглэлийн шударга</p>	<p>Шударга, тэгш байдлын аль зарчим үндсэн зарчим байх вэ гэдгийг хуулиар тогтоосон эсэх нь асуудалтай байгаа. Шударга, тэгш ёс гэдэг нь татварын дарамт нь татвар төлөгчийн төлөх чадвартай</p>

		байдлыг хуулиар тогтоогоогүй	пропорциональ байх ёстой гэсэн зарчим тусгагдаагүй
Татварын зарчим* тусгагдаагүй	Нэг толгой малд бүх татвар төлөгчид ижил татвар төлж байгаа - шударга бус	Татварын хэмжээ татвар төлөгчдийн малын тоотой хамааралтай тогтоогдоогүй	Гадны эх сурвалжийн мэдээлснээр МТТАТ нь харьцангуй пропорциональ байдаг. Татварын дарамт мал цөөнтэй этгээдэд мэдрэгдэж болох бөгөөд мал олонтой бол малаас орох орлого, малын тоог өсгөх стратегийн аль алинд нь дарамт учруулахгүйгээр татвараа төлж чаддаг ажээ.
Тэгш байдал: Ижил чадвартай татвар төлөгчид ижил хэмжээний татвар төлөх	Мал өмчлөгчид ялгаагүй албан ёсны татвар төлөгчөөр бүртгэгдсэн, малыг өрхийн бус, малчны өмчөөр тогтоосон	Бүх татвар төлөгчдөд ногдуулсан нэг төрлийн татварыг татварын элементүүдээр зохицуулахаар хуульчилсан.	Татварын тогтолцоо нь нэг төрлийн хэвтээ чиглэлтэй шударга, тэгш хэмээх ойлголтыг бодитоор нь тусгах боломжгүй. Хуулинд жендерийн талаар тусгайлан авч үзээгүй.
Татвар төлөлт: албан ёсны	Сумын ИТХ-аас тогтоосон хэмжээгээр тооцсон татварыг мал бүхий бүх этгээд албан ёсоор төлнө	Үндэслэл сайтай, орон нутгийн онцлогт тохируулж татварын хэмжээг тогтоох талаар хууль асуудалтай байгаа	Нутгийн иргэд улс төрийн ашиг харах нь илүү байгаагаас татвар ихээхэн хэлбэлзэлтэй тогтоогдож байна.
Татвар төлөлт:	Жилд тэнцүү хэмжээгээр 2 хувааж төлнө	Татвар төлөөгүй, дутуу төлөх, хугацаа хожимдуулах зөрчлийг хуульд тусгаагүй	Алаг-Эрдэнэ суманд 2021 оны татварын орлогын бараг тал хувь нь төлөгдөөгүй тохиолдол гарчээ. Ийм хууль зөрчсөн ямар ч орон нутгийн удирдлага, татвар төлөгчийг буруутай гэж үзээгүй.
Татвараас чөлөөлөх	Татвараас чөлөөлөхийг хуульд зөвшөөрөөгүй, гэхдээ хориглоогүй	Татвараас чөлөөлөх тухай заалт хуульд тусгагдаагүй	Төрийн өмчийн бэлчээрт мал нь бэлчээрлэж байгаа мал бүхий бүх этгээд татвар төлөх ёстой гэсэн үг.
МТТАТ-ын орлогыг сумын төсөвт төлөх	Татварын орлогыг сумын төсөвт төлөх заалт нь хуулийн гол зохицуулалтын нэг юм.	Орлогыг холбогдох журмын дагуу орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ. Энэхүү МТТАТ-ын эх үүсвэр нь орон нутгийн төсөвт төвлөрсөн төсвийн шилжүүлгийн нэг хэсэг болдог.	МТТАТ-ын орлогыг орон нутгийн хөгжлийн санд шилжүүлснээр орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого улсын төсөвт төвлөрсөн төсвийн удирдлагын хүрээнд зохицуулах асуудал үүсдэг. Гол оролцогч талуудтай хийсэн уулзалт, хэлэлцүүлгээр энэ татварын орлогыг ОНХС-аас тусгаарлахыг санал болгож байгаа.

Тэмдэглэл: Татварын зарчмыг 4.1-д тодруулж тусгасныг үзэх

#### 4.2.3 Тогтолцооны түвшний үнэлгээний хүрээнд МТТАТ-ыг хэрэгжүүлэх системийн тодорхойлолт

Өмнө үзүүлсэн хоёр хүснэгтэд татварын тогтолцооны үндсэн элементүүдийг тайлбарлаж, МТТАТ-ыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болох тогтолцооны түвшний үнэлгээтэй холбогдох зүйлийг онцлон авч үзлээ. МТТАТ-ыг хэрэгжүүлэх тогтолцооны хүрээний бүтцийн гол элементүүд болон туслах чанартай хүчин зүйлс, үйл ажиллагааг дүрслэн доор харуулсан болно.



ЗУРАГ 1. МТТАТ-ЫН ТОГТОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ ЗУРАГЛАЛ

Малын тоо толгойн албан татварын тогтолцооны үнэлгээний хүрээ				
	Татвар тогтоохоос өмнө		Шийдвэр гаргалт	Татвар ба бусад арга хэмжээ
Бэлтгэл үе шат	Сумын ИТХ-д өргөн барих			
Татвар төлөгчдийн тоо	Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох санал өргөн барих	Татварын нийт орлогыг багаар тооцож хамт өргөн барих	Татвар тогтоох тухай саналыг хэлэлцэх	Татварын мэдэгдлийг хүргүүлэх
Малын тоо, төрлөөр				Татварын орлогоор санхүүжүүлэх арга хэмжээний санал авах
Татварын нийт хэмжээг тооцох				Татвар хураах, төсөвт төвлөрүүлэх (жилд 2 удаа)
Татварын мэдэгдлийг бэлдэх, хүргүүлэх				Тухайн жилийн татварын төлөвлөгөөний биелэлт, зарцуулалтыг тайлагнах

МТТАТ-ын үнэлгээний хүрээг тодруулах үүднээс улсын хэмжээний болон зорилтот сумын зарим статистик мэдээллийг түүвэрлэн хүснэгт 6-д орууллаа.

Хүснэгт 6. МТТАТ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ /ҮНДЭСНИЙ БА ЗОРИЛТОТ СУМЫН МЭДЭЭЛЭЛ, 2022 ОНЫ БАЙДЛААР/

Үндэсний					Зорилтот сум /Алаг-Эрдэнэ/				
Малын тоо, сая толгой	Малчин өрх – татвар төлөгчид	Бусад татвар төлөгчид*, мал бүхий иргэд, бусад этгээдийг	Нийт татвар төлөгчид	Төлбөл зохих татвар, тэрбум төгрөг	Малын тоо, толгой	Малчин өрх – татвар төлөгчид	Бусад татвар төлөгчид*, мал бүхий иргэд, бусад этгээдийг	Нийт татвар төлөгчид	Төлбөл зохих татвар, сая төгрөг
71,120.43	190780	57516	248296	18-20	297,030	1050	248	1298	~100.0

\* - бусад татвар төлөгч гэдэгт суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, тавиул мал өмчлөгчдийг хамруулна

**МТТАТ-ыг хэрэгжүүлэх бүх тогтолцоо** нь сумын түвшинд татварын найдвартай суурьтай байх ёстой бөгөөд үүнд дараах амжилтын хүчин зүйлс болон тогтолцоог бүхэлд нь, бие даасан хариуцлагажуулахад дэмжих чиглэл үйл ажиллагаа багтсан байх ёстой. Тухайлбал:

1. МТТАТ-ыг хэрэгжүүлэх тогтолцоо нь малчин өрх, мал бүхий болон тавиул малын тоо толгойг төрөл тус бүрээр нь бодит тоогоор тооцно. Ер нь сумын хэмжээнд жил бүр тооллогыг боловсронгуй, сайн зохион байгуулж, малын тоог бодитой гаргах нь малын тоо толгойн татварын шударга, тэгш байдал, хэмжээг хангах гол түлхүүр юм. Малын генетик нөөцийн тухай хуульд заасан журмын дагуу сумын ХХААГ, сумын татварын алба хамтран татвар төлөгчдөд татварын мэдэгдлийн найдвартай мэдээллээр хангах;



2. Өмнө 1-д өгүүлсэн статистик мэдээллийг бүрдүүлснээр татвар ногдуулах, орлогын төлөвлөлт, зарцуулалтыг төлөвлөх зэрэг МТТАТ-ын хэрэгжилтийн тогтолцооны үйл ажиллагаа цогц болно. Түүнчлэн МТТАТ-ын хуульд татвар бууруулах, чөлөөлөх асуудал тусгагдаагүй, иймээс чөлөөлөх, хөнгөлөх (тэг татвар ногдуулахыг хөнгөлөх гэж үзэх эсэхийг хууль тодруулаагүй) явдалгүйгээр татварыг нарийн тооцоолон ногдуулж, бүрэн хураахад дөхөм болно.

3. МТТАТ-ын тухай хуульд заасанчлан татвар тогтоолт, төлөлтийг зөвхөн хуулиар зохицуулж, төлөх хугацааг тогтвортой мөрдөх нь энэ хуулийг амжилттай хэрэгжүүлж, татвар төлөгчид зохих ашиг хүртэх болно.

4. Татварыг дутуу төлөх, төлөх хугацааг хожимдуулах, дутуу төвлөрүүлэх, төсөвт төлөхөд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхгүй бол ийм буруу менежмент нь МТТАТ-ын хэрэгжилтийг мэдэгдэхүйц бууруулж, татварын суурь болох татвар төлөгчдийн дунд үл итгэх байдал газар авч тархах талтай.

5. Татвараа тогтмол бүрэн төлдөг татвар төлөгчдөд буруу жишиг болж магадгүй тул татвар төлөхөөс татгалзах, дутуу төлөх гэх мэт үйлдлүүдийг цаг тухайд нь таслан зогсоох арга хэмжээг сумын удирдлагаас мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд шуурхай авч байх;

6. Малын тоо, татварын тооцоог буруу, хуурамч мэдүүлсэн, удаа дараа төлбөрөө төлөөгүй, дутуу төлсөн тохиолдолд шалтгаан, сэдлийг сурвалжилж байх. Ингэснээр МТТАТ-ын тогтолцоо уян хатан бөгөөд татвар төлөгчдийн эрх ашгийн тулд хэрэгжүүлдэг болохыг харуулна;

7. Сумын малын бүртгэл, мөшгөх ажиллагааг шуурхай болгож, малын гадагш чиглэсэн нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг нарийн бүртгэх, албан ёсоор мэдээлж байх. Энэ нь малын тооны өөрчлөлтийг нарийн тогтоох, татвар ногдуулах, төвлөрүүлэхэд бусад сумтай хамтран ажиллах боломж олгоно.

#### **4.2.5 Өөрчлөлтийн онолыг малын татвартай холбон авч үзэхүй**


Мал аж ахуйн салбарт өөрчлөлтийн онолыг нутагшуулсан, хэрэглэсэн тухайд баталгаатай мэдээлэл хараахан байхгүй. Гэвч МТТАТ-н хэрэгжилтийг үнэлгээг өөрчлөлтийн онолтой хослуулан бэлчээрийн ашиглалтыг оновчтой болгох, бэлчээрийн доройтлыг сааруулах дүр зургыг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

Үнэн хэрэгтээ, шаталсан өөрчлөлтийг өдөөх хоёр арга бий: *нэгдүгээрт*, жилийн өсөлтийг бууруулж, сүргийн бүтцэд оновчтой өөрчлөлт оруулах; *хоёрдугаарт*: сумын түвшинд бэлчээрийн нөөцийн сайн төлөвлөлтөд суурилсан менежментийг нэвтрүүлэх, эвдрэл, доройтолд орсон бэлчээрийг сэргээх боломжтой болно.

МТТАТ-ыг тогтвортой хэрэгжүүлснээр бэлчээрийн нөөцийн ашиглалт болон малын тооны менежментэд суурь өөрчлөлт авчрах чадамжтай хэмээн үзэж байгаа бөгөөд тодруулбал, (i) УИХ-д өргөн барьсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах, (ii) бэлчээр ашиглалтын менежментийг өөрчлөх, гэрээнд суурилсан зохицуулалтыг нэвтрүүлэхэд өөрчлөлт шинэчлэлтийг идэвхжүүлэх, түүний дотор УИХ-д өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар бэлчээр ашиглалтын менежментийг өөрчлөх, гэрээт ашиглалтын зохицуулалтыг нэвтрүүлэхэд ихээхэн түлхэц өгнө. Малын тоог ашиглуулж байгаа

бэлчээрийн даацад нийцүүлэх үүргийг малчдын бүлгүүд гэрээгээр хүлээх; (iii) бэлчээрийн оновчтой менежментээр гэрээт бэлчээрийг сэргээх; (iii) малаас олох орлогыг бууруулахгүйн тулд үржлийн ажлын үр ашиг, тэжээлийн хангамжийг сайжруулах замаар малын ашиг шимийг нэмэгдүүлэх; болон (iv) зорилтот үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэхийн тулд татварын орлогоос санхүүжилт авах, үүний тулд МТГАТ төлөх шаардлагатай. Эдгээр үйл ажиллагаа нь нэг нэгнээ харилцан нөхөж, SCALA хөтөлбөрийн өөрчлөлтийн онолд нийцэхээр харагдаж байна.

ТАХИРМАГ 7. УРТ ХУГАЦААНЫ ХУВЬСГАГЧ ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛЫН ДҮРСЛЭЛ



Эх үүсвэр: СКАЛИА төслийн тайлангаас

#### 4.2.6 Хувийн хэвшлийн оролцоо

Малын толгойн татвар нь малчдыг сургах санаачлага, ялангуяа тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай нүүдэлчдийн дадлагын дүрмийг батлахад дэмжлэг үзүүлэх үнэт эх үүсвэр болж чадна. Энэхүү сургалт нь малчдад малын гаралтай бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулж, зах зээл дээр өндөр үнээр авах боломжийг олгодог. Тухайлбал, Монгол Улсын стандарт хоршоо зэрэг байгууллагууд дээрх стандартыг мөрддөг малчдаас мах, арьс шир, хонины сүүл, ноолуур худалдан авч, бүтээгдэхүүний чанарт нь тулгуурлан урамшуулал олгодог. Нэг ёсондоо хувийн хэвшлийнхнээс малын гаралтай бүтээгдэхүүн худалдан авахад чанарын стандарт тогтоосноор малчдыг бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, үржлийн дадал зуршилд анхаарлаа хандуулахыг дэмжиж байгаа юм. Малын толгойн албан татварыг эдгээр стандарттай холбосноор малчид 10-20 хувийн нэмэлт орлоготой болохын зэрэгцээ бэлчээрийн нөхцөл, малын эрүүл мэнд, нөхөн үржихүйн үзүүлэлтийг сайжруулах боломжтой юм.

## ТАВДУГААР БҮЛЭГ

# МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААРХ МАЛЧИД- ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ҮНЭЛЭМЖИЙН ТОЙМ: ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЖИШЭЭН ДЭЭР

## 5.1 Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол

Гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд хээрийн судалгаа явууллаа. Шинээр мөрдөгдөж буй татварын хуулийг хэрэгжүүлэх бүх ажлыг сумын захиргаа болон татвар төлөгчдийн аль алиных нь хувьд эхлүүлэх албан ёсны цорын ганц шийдвэр бол сумын ИТХ-ын хуралдааны тогтоол юм. МТТАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр сумын ИТХ-аас 2021 оны нэгдүгээр сард анхны захирамж гаргажээ. Сумын ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны тогтоолоор нэг толгойд ногдуулах албан татварыг адуунд 500₮, үхэрт 500₮, хонинд 300₮, ямаанд 700₮, тэмээнд – 0 төгрөгөөр тогтоожээ .

## ЗУРАГ 2. СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ, АЛАГ-ЭРДЭНЭ СУМ, ХӨВСГӨЛ АЙМАГ



**ХӨВСГӨЛ АЙМАГ АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**  
2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 02

Манхан

**МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДУУЛАХ ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "д" заалт, Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 3 дугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

- 1.Өмнөх жилийн мал тооллогын дүнгээр тоологдсон малын толгой тутамд адуу 500, үхэр 500, хонь 300, ямаа 700, тэмээ 0 төгрөгөөр тус тус тооцон албан татварыг ногдуулсугай.
- 2.Сум, тосгоны нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээдээс албан татварыг хуулийн хугацаанд төвлөрүүлж, зарцуулалтын тайланг иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (З.Ням-Очир) тосгоны Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Баттүшиг) нарт үүрэг болгосугай.
- 3.Батлагдсан тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж "Захиргааны хэм хэмжээний акт"-ын нэгдсэн санд бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Даринчулуун)-д үүрэг болгосугай.
- 4.Тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актад бүртгэсний дараа мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (З.Ням-Очир), тосгоны Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Баттүшиг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЖАНЛАВ

Сумын ИТХ-ын тогтоолд хуулийн зарим үндэслэлийг дурдаж, аливаа шийдвэр гаргах үйл явцын эрх зүйн үндсийг тодорхой болгох шаардлагатай байна. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” шинэчилсэн найруулгыг 2020

оны 2020 оны 12 сарын 24 өдөр баталснаар сумын хуралдааны тогтоолд ишлэл авсан 8 хуулийн дугаар зүйлийн 18.1.2-т “г” заалт хүчингүй болсон.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг иш татсан нь энэ хуулийн зарим заалттай зөрчилдөж байна, учир нь 6.2-т татварын хэмжээг зөвхөн сумын ИТХ тогтоох эрхтэй гэсэн бөгөөд ИТХ-д хамаарах үүнээс өөр заалт байхгүй.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар хуралдааны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Алаг-Эрдэнэ сумын бэлчээр ашиглалтын хариуцлагын журам" нь сумын бэлчээрийг нөөц, бүтээмжид тохируулан хамгаалах, бэлчээр ашиглалтыг оновчтой болгоход чиглэгдсэн болно. Уг журамд холбогдох хууль тогтоомж, холбогдох заалтыг тусгаагүй учир уг журамд заасан үйл ажиллагаа, арга хэмжээний аль нь ямар хуульд хамаарахыг ойлгоход хүндрэлтэй байгаа.

Гуравдугаар бүлэг “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээрийн хуваарийн хэрэгжилт”-т МТТАТ-ын тухай хуулийн гол заалтуудыг хэрэгжүүлэх, төлөвлөлт, хяналтын үйл явцын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг түлхүү тусгах боломж байгаа юм. Тухайлбал:

- Бэлчээрийн даацын хэтрэлт, ургамлын нөмрөгийн доройтлыг таслан зогсоох зорилгоор улирлын болон улирал хоорондын сэлгээ, бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх, амрах, ашиглалтын эрчмийг бууруулах зэрэг менежментийн арга хэмжээ авах;
- Сумын нийт бэлчээрийн 10 хувьтай тэнцэх нөөц бэлчээр бий болгож, оновчтой менежментээр зохистой ашиглах;
  - Ашиглалт багатай бэлчээрийн усан хангамжийг сайжруулах;
  - Алслагдсан бэлчээр болон ашиглалтгүй бэлчээрт хүрэх замыг засварлах, шинээр зам гаргах;
  - Байгалийн хадлангийн хэмжээг нэмэгдүүлж, малын тэжээлийн хангамжийг сайжруулах;
  - Хадлангийн талбайг хашиж хамгаалах, таримал хадлан бий болгох;

## **5.2 Алаг-Эрдэнэ сумын МТТАТ-ын орлогын төлөвлөлт, зарцуулалт**

2022 онд Алаг-Эрдэнэ сум 100 орчим сая төгрөгийн татварын орлого хураан төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эцсийн тооцоогоор татварын орлого 87.8 сая төгрөг болж, 75 сая төгрөгийг шинээр худаг гаргах, сумдын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, малчдыг сургах, сургах зэрэгт зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 7. МТГАТ-ЫН ОРЛОГООР САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭ, 2023 ОНЫ БАЙДЛААР

Арга хэмжээ ба татварын орлогоос олгох нийт санхүүжилт, мянган төгрөг							Дүн
Худаг гаргах	Малын эрүүл мэнд	Блчээрийн хортон, мэрэгчидтэй тэмцэх	Малчдад зориулсан сургалт	Тэжээлийн нөөц бүрдүүлэх, тэжээлийн агуулах барих	Малын чанарыг сайжруулах	Мал сүрцгийг гэмт халдлагаас хамгаалах	
90000.0	22000.0	1000.0	10000.0	10000.0	26300.0	3000.0	<b>161300.0</b>

Эх сурвалж: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Алаг-Эрдэнэ сум, 2023

2023 оны эхний хагас жилийн байдлаар 100 сая төгрөг төлөвлөснөөс 60.1 сая төгрөг төвлөрүүлээд байна. Энэ орлогыг сумын ЗДТГ-аас төлөвлөснөөр 4 худаг шинээр гаргах, өвсний агуулах барих, аюулгүй тэжээлийн нөөц бүрдүүлэх, малын үүлдэрлэг байдлыг сайжруулах, мал эмнэлэг, малын хашаа хороо ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэрэгт зарцуулна. МТГАТ-ын орлогыг төлөвлөх, хуваарилахтай холбоотой дээрх мэдээллээс харахад мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг ажлыг орон нутагт шийдвэрлэх шаардлага их байгааг харуулж байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасан 12 төрлийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн журамд мөн тусгажээ. Эдгээр үйл ажиллагааг татварын орлогоор дэмжихээр заасан бөгөөд үүнд бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зэрэг багтсан болно. Татварын орлогоор санхүүжүүлэх санал малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэх, бэлчээрийн ба мал аж ахуйн менежментийг сайжруулан өөрчлөх гол асуудалд чиглэж байгаа нь, хэрэв амжилттай хэрэгжүүлж чадвал цаад агуулгаараа тооноос чанарт шилжих урьдчилсан нөхцөл эсхүл зайлшгүй шаардлагатай урьдчилсан нөхцөл болж өгөх тааламжтай хандлага юм.

**5.3 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд зөвлөх нь:**

Орон нутгийн өөрөө удирдах ёсны тогтолцоотой цорын ганц шийдвэр гаргах байгууллага болохын хувьд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, хурлын төлөөлөгчдөд өндөр эрх мэдэл, онцгой үүрэг хүлээлгэсэн болно. Хурал үүргээ биелүүлэхийн тулд 10-р хүснэгтэд үзүүлсэн зарим асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

ХҮСНЭГТ 8. ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ӨГӨХ ҮНДСЭН ЗӨВЛӨМЖҮҮД

Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд ажиглагдаж буй анхаарах асуудлууд	Цаашид харгалзах зөвлөмж
Хороо зэрэг хурлын байгууллагын дотоод нэгжийн чиг үүргийг сайжруулж, сумын Засаг дарга, ЗДТГ	<ul style="list-style-type: none"> <li>Хороодын чиг үүргийг боловсронгуй болгох - хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, зөвлөмж гаргах,</li> <li>Хурлын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий хороодыг идэвхжүүлэх;</li> </ul>



<p>болон бусад мэргэжлийн нэгжүүдтэй харилцах уялдаа холбоог сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын ЗДТГ-тай хамтран ажиллах хороодын чадавхыг идэвхжүүлж, хөгжүүлэх;</li> <li>• Хурлын хороод болон сумын төрийн захиргааны мэргэжлийн нэгж хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх шинэ арга барилыг нэвтрүүлэх.</li> </ul>
<p>Хурлын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа, ялангуяа МТТАТ-тай холбоотой үйл ажиллагааны талаар иргэдийн ойлголт сул байна.</p>	<p>Хурал байгуулагдсаныхаа дараа олон нийт, сонгогчдын дунд сурталчлах зорилгоор хэд хэдэн ажлыг санаачлах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинээр сонгогдсон гишүүдийн эрх үүрэг, ажил үүргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх тогтвортой механизм бий болгох;</li> <li>• Сумын ИТХ, багийн НХ-ын төлөөлөгчдийг сонгогчдод танилцуулах тусгай арга хэмжээ зохион байгуулж, тэд хоорондоо танигдаж, харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах.</li> </ul>
<p>Сонгуульт ажилдаа дадлагажихад нь шинээр сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Тодорхой үүрэг бүхий хороонд эмэгтэйчүүдийг оруулах Эмэгтэй төлөөлөгчдийг сонгогчидтойгоо байнгын холбоотой байх талаар сумын ЗДТГ-тай хамтран ажиллах.</p>
<p>ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нь иргэдэд ямар давуу талтай, ямар ашигтайг иргэд мэдэхгүй.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сонгогчдыг соён гэгээрүүлэх талаар өмнөх хурал болон түүний төлөөлөгчдийн гаргасан доголдолтой асуудлууд, энэ талаарх сонгогчдын дунд байгаа аливаа ташаа ойлголтыг залруулахын төлөө шаргуу ажиллах;</li> <li>• Хурал “Хурлын төлөөлөгч-сонгогчид” хуваарьтай уулзалтуудыг санаачлан зохион байгуулж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх харилцан хүлээн зөвшөөрсөн шийдэлд хүрэх, ялангуяа татвар төлөгчдөд МТТАТ-ын орлогоос ашиг хүртэх боломжийг хангах;</li> </ul>
<p>Хурлаас МТТАТ-ын талаар гаргах шийдвэрээ холбогдох хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын дагуу сайтар боловсруулж байх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• МТТАТ-ын талаар гаргаж буй шийдвэрээ бодит тоо баримт, тооцоонд тулгуурлан гаргахад ИТХ-ын Зөвлөл, дарга анхаарах;</li> <li>• Хуралдаанаас гаргасан тогтоолд:             <ul style="list-style-type: none"> <li>o МТТАТ-ын орлогыг зарцуулахад хяналт тавих талаар төлөөлөгчдөд зөвлөмж өгөх;</li> <li>o тогтоолын биелэлтийг хариуцах субъектүүдийг тодорхой зааварчилга, аргачилсан зөвлөмжөөр хангах;</li> </ul> </li> </ul>
<p>МТТАТ-ын орлого төвлөрүүлэх, зарцуулахад ИТХ-аас тавих хяналтыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• БИНХ-аар дэмжигдсэн саналыг ажил хэрэг болгох, хэрэгжүүлэхэд цаг алдалгүй шуурхай хандах нь хурлын байгууллага болон сонгогчдын холбоог бэхжүүлж, мэдээлэл солилцоход хөтөч болно</li> <li>• Хурал МТТАТ-ын орлогоор санхүүжүүлэх саналыг сумын ойрын болон дунд хугацааны хөгжлийн стратеги, төлөвлөгөөнд тусгах;</li> <li>• Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бүрдүүлэх, шийдвэр гаргах, тулгамдаж буй асуудал, асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоо хэчнээн чухал болохыг удирдлага, ИТХ-ын гишүүд мэддэг байх ёстой.</li> </ul>
<p>Иргэд хурлын байгууллагын үр нөлөөний талаар сэтгэл ханамжтай холбоотой асуудал бий</p>	<p>Хурал хуулиар хүлээн үүргээ биелүүлэхийн тулд шинээр гарч ирж буй боломжийг илүү сайн ашиглах ёстой бөгөөд үүний нэг нь МТТАТ болон төсвийн эх үүсвэрт оруулж буй хувь нэмэр юм.</p> <p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48.1-д заасны дагуу сумын Хурал өөрийн бүтцийн хүрээнд хороодыг байгуулна.</p> <p>Хөдөө аж ахуй, газар, төсвийн чиглэлээр орон нутгийн түвшинд шийдвэр гаргах чиглэлээр мэргэшсэн хороод байдаг бөгөөд үүнд хоёр үндсэн чиглэл багтдаг.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төсөв, санхүү, эдийн засгийн хөгжлийн хороог чиг үүргийнхээ хүрээнд ЗТБХБ-д чиглүүлэх;</li> <li>2. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо нь мал аж ахуй, газар тариалан, бэлчээр, усны чиглэлээр хийгдэх чухал ажлуудыг МТТАТ-аас дэмжих;</li> <li>3. Хороо нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын биелэлтэд хяналт тавьж, төсөв,</li> </ol>

Засгийн газрын шилжүүлгийн зарцуулалтад хяналт тавих;

#### 5.4 Сумын ИТХ-ын төлөөлөгчдөд зөвлөх нь:

ИТХ-ын төлөөлөгчдөөс сумынхаа хөгжил, олон нийтийн төлөөнөө гүйцэтгэх үүргийн талаар зарим зөвлөгөө өгөх хэрэгтэй байна.

#### Хүснэгт 9. ИТХ-ын төлөөлөгчдөөс анхаарах асуудал, зөвлөмж

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаанд ажиглагдаж буй анхаарах асуудлууд	Цаашид харгалзах зөвлөмж
Хөдөөгийн багаас сонгогдсон төлөөлөгчид (сумын төвийн багаас бусад) сонгогдсон багийнхаа л асуудлыг арай түлхүү дэмждэг буюу асуудалд жигд ханддаггүй тал цөөн бус ажиглагддаг	<ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлэг, шийдвэр гаргахад төлөөлөгчид ба сонгогчдын эрх ашиг харилцан нийцсэн байдлыг хангах;</li> <li>Төлөөлөгчид оновчтой санал гаргах, зөвлөгөө өгөх талаар чадваржих, асуудал хэлэлцэхэд бэлтгэлтэй хандах</li> <li>Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай дэлгэрэнгүй танилцаж, хариуцлагатай хандах, саналаа зөв, оновчтой илэрхийлэх</li> </ul>
• Сонгогчидтой харилцаа, холбоо сул байгаа нь сонгогчдод тулгамдаж байгаа асуудлыг онож шийдвэрлэх боломжийг алдаж байна.	<ul style="list-style-type: none"> <li>Сонгогчдоос өөрсдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал гаргуулахад санаачилгатай хандаж байх;</li> <li>Сумын ИТХ, БИНХ-ын төлөөлөгчдийн хоорондын ажил төрлийн холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх</li> </ul>
МТТАТ-ын тухай хууль батлагдсанаас хойших хугацаа нь нийт төлөөлөгчдийн хувьд хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, зохицуулалтын талаар хангалттай мэдлэг, ойлголттой болоход богино хугацаа байсан нь цаашид идэвхтэй ажиллах шаардлагыг бий болгож байгаа	<ul style="list-style-type: none"> <li>МТТАТ-ын орлогоос санхүүжилт авах шалгуурыг хангасан тодорхой санал боловсруулж, багийн ИТХ-аар дэмжүүлэх, сумын ИТХ-аар батлуулах ажилд сонгогч малчдын идэвхтэй зөвлөх байх</li> <li>Орон нутгийн төсөв, тэр дундаа МТТАТ-ын орлогоор хэрэгжүүлэх арга хэмжээ нь сумын урт, дунд, богино хугацааны хөгжлийн хөтөлбөр, зорилттой нийцэж байгаа эсэхийг байнга нягталж байх.</li> </ul>
Сонгогчдод шаардлагатай мэдээлэл авахад сонгосон төлөөлөгчийн идэвхтэй тусламж, санаачилгатай оролцоо дутагдаж байна	Хөгжлийн чиг хандлага болон ИТХ-аас гаргасан шийдвэртэй холбогдох мэдээллийг сонгогчдод өөрийн биеэр хүргэж, тайлбарлаж, мэдээлэх
Сонгосон бүх төлөөлөгчид байнга зөвлөж, хамтран ажиллахгүй байгаагаас сонгогчид МТТАТ-ын орлогоос үр өгөөжтэй хүртэх вэ гэдэг дээр сонгогчид доголдож байна.	<ul style="list-style-type: none"> <li>МТТАТ-ын орлогоос санхүүждэг арга хэмжээний хэрэгжилтийг биечлэн санаачлах, хэрэгжилтийг хангахын тулд бусад төлөөлөгчидтэй хамтран шалгаж, зохих шаардлагыг хүргүүлэх.</li> <li>Орон нутгийн төсөв, тэр дундаа МТТАТ-ын орлогоо хэрэгжүүлэх арга хэмжээ нь сумын хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөтөлбөр, зорилттой нийцэж байх шаардлагыг сонгогчдод тодорхой таниулах, өөрсдийн шугамаар хянаж байх.</li> </ul>

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолтой танилцан ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, сумын ЗДТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлагыг үндэслэн ИТХ-ын хуралдааны тогтоол, сумын Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж Хавсралт 2-т хавсаргав.

#### 5.5 Алаг-Эрдэнэ суманд явуулсан асуумжийн судалгааны дүн




Энэ хэсэгт нэг сумыг жишээ болгон авч, асуулгын судалгааны үр дүнд тулгуурлан малчин өрх, татвар төлөгчид саяхан хэрэгжиж эхэлсэн МТТАТ-ын тухай хуульд хэрхэн хандаж байгаад дүн шинжилгээ хийсэн болно. МТТАТ-ын хэрэгжилтэд татвар төлөгчдийн хандлагын үндсэн болон хамаарах мэдээлэл, аман мэдээлэл цуглуулах асуумжийн судалгааг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд явууллаа. Энэхүү судалгааг МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилт хэр ахицтай байгаа, татвар төлөгчид хэрэгжилтийн үйл ажиллагаанд хэрхэн хандаж байгааг үнэлэх зорилготой байсан болно.

### 5.5.1 МТТАТ-ын талаар татвар төлөгчид мэдээлэл авсан байдал

Тогтолцооны, эсхүл үйл явцын байна уу, хөгжлийн бодлогын зорилт ба татвараар дамжуулан орон нутгийн бодлого, ирээдүйн зорилгод үр дүнтэй, нөлөө бүхий хувь нэмэр оруулах боломжтой зорилгыг татварын үнэлгээ чиглэх ёстой. Үнэлгээ бол татварын тодорхой хөнгөлөлтийг нэвтрүүлэх, хадгалах нь зүйтэй эсэх, ийм хандлагын үр нөлөөний талаарх тоон болон чанарын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулагчдад мэдээлэх зорилготой үйл явц гэж хэлж болно.

Доор үзүүлсэн тахирмагаас ахмад, залуу малчид, мал бүхий этгээд өөрсдийгөө илүү мэдээлэлтэй, сайн мэдлэгтэй гэж үнэлж байна. Мэдээлэл сайн, дунд зэрэг авсан гэж хариулсан хэсгийг нэгтгэн харьцуулбал, дунд насны оролцогчид хангалттай хувийг харуулж байна.

ТАХИРМАГ 8. МТТАТ-ЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ХЭР ЗЭРЭГ АВСАН ТУХАЙ ХАРИУЛТ, ХУВЬ




Залуу болон дунд насны ангилалд хамрагдагсдын дунд мэдээлэл “бага” гэсэн хариулт өндөр хувьтай басан бол "сайн" гэсэн хариултын эзлэх хувь 50 хувь буюу судалгаанд оролцогчдын талаас илүү нь МТТАТ-ын талаар сайн мэдээлэлтэй байна гэж дүгнэж болно. Сайн, дунд зэрэг мэдээлэлтэй гэснийг харвал, эрэгтэйчүүд илүү өндөр, харин эмэгтэйчүүд ¼-ээр бага байна. Хэрэв "мэдэхгүй" гэсэн хариултаас бусад гурван хариултыг нэгтгэвэл хоёр хүйсийн бүлэг бараг ижил - 90 гаруй хувьтай байна.

### 5.5.2 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн талаарх татвар төлөгчдийн бодит мэдлэг

Төлбөл зохих татварыг ямар хэмжээгээр тооцдог талаар малчид мэдлэг сайтай гэж үзэхээр дүн асуумжаас гарлаа. Тодруулахад залуу малчдаас өгсөн “мэдэхгүй” гэсэн хариулт өндөр хувьтай, харин дунд ба ахмад насныхан татварын хэмжээг мөнгөн дүнгээр мэдэж байгаа гэх хариулт дунд насныханд илүү байна.

ТАХИРМАГ 9. МТГАТ-ЫН МӨНГӨӨР ТОГТООСОН ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЛЭГ, ХУВЬ




А. Янз бүрийн насны малчдын хариулт

Б. Жендерээс хамаарсан хариултын байдал

“Би мэднэ” гэсэн хариулт бараг ялгаагүй, гэхдээ эрэгтэйчүүдийн хувьд ялимгүй илүү – 7 хувь орчим байна.

50-иас дээш насны ахмад малчид сумын ИТХ-аас тогтоосон татварын хэмжээг тэдний хувьд боломжийн гэсэн бол асуумжид оролцогчдын нас залуужихын хэрээр буурч байна. 50 ба 35-50-аас дээш насны малчид энэ үзүүлэлтийг өндөр гэж үзэж байгаа бол залуу малчдын “мэдэхгүй” гэж өндөр хувьтай хариулсантай холбогдон “мэднэ” гэсэн хариулт буурч гарлаа.

ТАХИРМАГ 10. МТГАТ-ЫН ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МАЛЧДЫН ҮНЭЛЭМЖ, НАСААР, ХУВЬ



Татварыг хэрхэн төлөх боломжтой вэ гэсэн асуултад хоёр хүйсийн малчдын хариулт 65.5% байна. Эрэгтэйчүүд татварыг бага зэрэг өндөр гэсэн бол малчин эмэгтэйчүүд бага гэж үзэх байгаа гэлээ.

#### ХҮСНЭГТ 10. МТТАТ-ЫГ ТӨЛӨХ БОЛОМЖ: ХАРИУЛАГЧДЫН ХҮЙС БА ӨРХИЙН БАЙДАЛ

Хариулагчдын хүйс	Хариулт	Хувь
Эмэгтэй	Өндөр	15.2
	Боломжтой	66.7
	Боломжгүй	0.0
	Мэдэхгүй	18.2
Эрэгтэй	Өндөр	22.4
	Боломжтой	64.2
	Боломжгүй	6.0
	Мэдэхгүй	7.5

Өрх	Хариулт	Хувь
Ганц бие толгойлсон өрх	Өндөр	11.1
	Боломжтой	66.7
	Боломжгүй	0.0
	Мэдэхгүй	22.2
Хэвийн	Өндөр	23.3
	Боломжтой	64.4
	Боломжгүй	6.7
	Мэдэхгүй	5.6

Олонх малчин өрх, тэр дундаа өрх толгойлсон өрхийн төлөөллийн өгсөн хариултаас үзвэл татвар боломжийн тогтоогдсон гэж дүгнэхээр байна. Хачирхалтай нь, хэвийн өрхүүд харин өндөр гэж үздэг - бараг 1/5 нь. Татвараа төлөх боломжийн талаар ойлголт арай дутмаг, өөрөөр хэлбэл татвараа төлж чадна гэсэн хариулт ганц бие толгойлогчтой өрхөд илүү байгаа тал харагдлаа.

#### 5.5.3 МТТАТ-ын төлөлт

2020 оны мал тооллогын статистик мэдээнд үндэслэн 2021 онд МТТАТ-ыг тогтоож, төлбөрийг эхлүүлсэн, түүнээс хойш татвар ногдуулах, төвлөрүүлэх ажил явагдаж байна. Сум, аймгийн түвшний мэдэгдлийг ашиглан доор үзүүлсэн нотлох баримт үүсгэх, энгийн тооцоолол хийх боломжтой. 2021 оны төсвийн жил МТТАТ төлөгчдийн 81.2-100 хувь нь бүх татвараа төлсөн нь хамгийн амжилттай жил байлаа.

#### ХҮСНЭГТ 11. МТТАТ-ЫН ТӨЛӨЛТ, 2021-2022, АЛАГ-ЭРДЭНЭ СУМ, ХУВЬ

Малын тооны бүлэглэл*	Татвар төлсөн байдал	2021 оны байдлаар, %	2022 оны байдлаар, %	Зөрүү, %	Тодруулга
100 хүртэл толгой малтай	Бүрэн төлсөн	81.82	40.91	-40.91	багассан
	Дутуу төлсөн	4.55	9.09	4.55	нэмэгдсэн
	Төлөөгүй	13.64	50.00	36.36	нэмэгдсэн
101-200 толгой малтай	Бүрэн төлсөн	95.45	50.00	-45.45	багассан
	Дутуу төлсөн	0.00	13.64	13.64	нэмэгдсэн
	Төлөөгүй	4.55	36.36	31.82	нэмэгдсэн
201-500 толгой малтай	Бүрэн төлсөн	97.06	64.71	-32.35	багассан
	Дутуу төлсөн	0.00	11.76	11.76	нэмэгдсэн
	Төлөөгүй	2.94	23.53	20.59	нэмэгдсэн
501-800 толгой малтай	Бүрэн төлсөн	93.33	78.57	-14.76	багассан
	Дутуу төлсөн	0.00	7.14	7.14	нэмэгдсэн
	Төлөөгүй	6.67	21.43	14.76	нэмэгдсэн
800 ба дээш толгой малтай	Бүрэн төлсөн	100.00	57.14	-42.86	багассан
	Дутуу төлсөн	0.00	0.00	0.00	нэмэгдсэн
	Төлөөгүй	0.00	42.86	42.86	нэмэгдсэн

Тэмдэглэл: \* өмчийн малын бодит тоон дээр үндэслэн тооцов.

Гэсэн хэдий ч 2022 онд байдал эрс өөрчлөгдсөн бөгөөд малын тооны бүх бүлгийн татвар төлөлтийн хувь мэдэгдэхүйц буурчээ: татвар төлсөн болон төлөөгүй өрхийн эзлэх хувь бараг тэнцүү байна. Төлбөрийн хэмжээ хамгийн их буурсан бүлэг гэвэл 501-800 толгой малтай, дараа нь 201-500 толгой малтай, хамгийн баян нь буюу 800 ба түүнээс дээш толгой малтай малчин өрх удаалсан бол эсрэгээр 101-200 толгой малтай өрх бусад бүлгээс бүтэн төлөлтийн үзүүлэлтээр илүү гарлаа.


Төлөлт огцом бууралт нь мал олонтой өрхийн төлөлт 23.5-42.8 хувиар тасалдсантай холбоотой. Онцлоход, малын тоогоор дундаж өрхүүдийн татварын төлөлтийн бууралт бусад хоёр бүлгийнхээс бага, татвар төлөлтөд арай ухамсартай хандаж байгаа нь харагдлаа. Татвараа дутуу төлсөн тохиолдол бүх бүлэгт байгаа - дунджаар 10-15 хувь байна.

Хэрэв орлого сайтай төлөгчид татварын нийт орлогод өндөр хувийг эзэлж байвал татварын тогтолцоо зохистой байдлын гол шалгуурын нэг нь хангагдаж байна гэж үздэг. Харин эсрэгээрээ өндөр татвар төлөгчдийн сумын татварын орлогод оруулсан хувь 42.8 хувиар буурсан байна. Энэ нь нэг загварын (өсгөн нэмэгдүүлсэн бус) татварын ерөнхий зарчмаас гажсан хэрэг юм.

#### 5.5.4 Сумын ИТХ-аас тогтоосон татварын хэмжээний тухай үнэлэмж

Доорх тахирмагаас үзвэл дунд насны малчид татварын талаар илүү мэдээлэлтэй гэмээр байна. Гэтэл 35-аас доош насны 5 залуу малчны нэг нь "мэдэхгүй" гэж хариулсан нь тэдний бичиг үсэгт тайлагдалт доогуур байгаатай холбоотой байж болох юм. Учир нь 1990-ээд оны дунд үе, 2000-аад оны эхээр сургуулийн насны олон хүүхэд сургуулиас завсардсан, тэгээд ч нэлээд нь дахин сургуульд суугаагүй.

ТАХИРМАГ 11. МЭДЭЭЛЭЛ АВСАН БАЙДАЛ



Жил бүрийн татварын мэдэгдлийг хүргүүлэх нь сумын захиргааны зүгээс хийж буй гол ажлын нэг гэдгийг удирдлагууд онцолж байна. Ихэвчлэн татварын байцаагч, багийн дарга нар болон бусад албан хаагчид тодорхой хэмжээний зардал гаргаж тараадаг. Гэтэл энэ арга хэмжээтэй холбоотой зардлыг татварын орлогоос санхүүжүүлэх заалт МТТАТ-ын тухай хуульд байхгүй.

### 5.5.5 МТТ-н татвар төлөх эх үүсвэр

Малын тооны янз бүрийн бүлэглэлд хамаарах татвар төлөгчид чухамдаа ямар эх үүсвэрээр татвараа төлдгийг тодорхойлох нь сонирхол татах зүйл юм. Асуумжид хамрагдсан малчдын хариултаас үзэхэд мал борлуулалт нь МТТАТ-ыг төлдөг нийтлэг эх үүсвэр ажээ. Тахирмаг 12-т үзүүлсэнчлэн цөөн малтай өрхийн хувьд татвараа төлсөн эх үүсвэрийн дотор мал борлуулалт 35 гаруй хувийг эзэлдэг бол дараа нь тэтгэвэр, тэтгэмж ордог. Энэ бүлгийн нэг онцлог нь малчин өрхүүд татварт 8 хүртэл тооны өөр өөр эх үүсвэр ашигладаг.

ТАХИРМАГ 12. МТГАТ ТӨЛДӨГ НИЙТЛЭГ ЭХ ҮҮСВЭР

А. Цөөн малтай өрх



Мал борлуулж татвараа төлөх эх үүсвэрээ бүрдүүлдэг хандлага дундаж болон олон малтай өрх дээр тодорхой байгааг асуумжийн дүнгээс харж болно. Хувилж үзвэл, өрхийн малын тоо толгой өсөхийн хэрээр мал борлуулалт дагаж нэмэгддэг нь үүний нэг нотолгоо юм.

Б. Дундаж ба олон малтай өрх



Тэмдэглээ: 800+ (800 ба түүнээс олон малтай)

Тодруулбал, 800 толгойгоос олон малтай чинээлэг малчин өрх татварыг зөвхөн мал борлуулсан орлогоосоо төлдөг гэсэн нь онцлох кэйс мөн.

Татвараа бүрэн төлөхөд ямар нэг байдлаар хүндрэлтэй байдаг гэж тэнцүү хувь бүхий (22.7 хувь) 4 шалтгааныг 100 толгой хүртэл малтай өрх нэрлэжээ.

ХҮСНЭГТ 12. “ТА ЯАГААД ТАТВАРАА ТӨЛӨӨГҮЙ ВЭ?” АСУУЛТАД ӨГСӨН ХАРИУЛТ

А.500 хүртэл толгой малтай өрх (10 хүртэл толгой малтай өрхөөс эхлэн 500 толгой хүртэл)

Малын тооны бүлэглэл	Татвар төлөөгүй шалтгаан, тайлбар	Эзлэх хувь
100 хүртэл толгой малтай	Татвар төлөхөөр заасан хугацаа малчин өрх ахиу орлоготой байх үетэй таарахгүй, зөрдөг	22.7
	Татварыг цувруулан төлж болдоггүй, заавал хоёр хувааж тэнцүү төлөх нь таарамжгүй	22.7
	Малчин өрх, мал бүхий этгээд тавиул малтай адил хэмжээний татвар төлөх нь зохисгүй	22.7
	Малаа цөөллөө гээд татвар дагаж буурдаггүй	9.1
	Татвар өрхийн амьжиргаанд хүндрэл үзүүлдэг	22.7
101-200 толгой малтай	Татвар төлөхөөр заасан хугацаа малчин өрх ахиу орлоготой байх үетэй таарахгүй, зөрдөг	38.1
	Татварыг цувруулан төлж болдоггүй, заавал хоёр хувааж тэнцүү төлөх нь таарамжгүй	14.3
	Малчин өрх, мал бүхий этгээд тавиул малтай адил хэмжээний татвар төлөх нь зохисгүй	23.8
	Татвар төлөө гээд ашиг хүртэх баталгаа байхгүй	23.8
201-500 толгой малтай	Татвар төлөхөөр заасан хугацаа малчин өрх ахиу орлоготой байх үетэй таарахгүй, зөрдөг	12.5
	Малчин өрх, мал бүхий этгээд тавиул малтай адил хэмжээний татвар төлөх нь зохисгүй	25.0
	Татвар өндөр	12.5
	Малаа цөөллөө гээд татвар дагаж буурдаггүй	28.1
	Татвар төлөө гээд өгөөж хүртэх баталгаа байхгүй	21.9

Малын тоо өсөхийн хэрээр өмчлөгчид нь татварын бодлогын тэгш бус байдал, үр өгөөжийн тодорхойгүй байдал зэрэг ерөнхий талыг үнэлэх хандлагатай байдаг. Энэ асуудлыг 200-аас дээш толгой малтай татвар төлөгчдийг төлөөлөх дөрвөн оролцогчийн нэг нь хураамж төлөхгүй гэсэн шалтаг болгон гаргаж тавих хандлага ажиглагдаж байна.

### ШИГТГЭЭ 2

*Манайх 30-аад толгой бог малтай, таван мянган төгрөгийн татварын мэдэгдэл авсан. Манай мал тийм хэмжээний татвар төлөх орлого бүрдүүлэхэд хараахан хүрэхгүй. Цөөн малтай болохоор хангалттай цөөлж бас чадахгүй. Тиймээс татвар манайд боломжийн өгөөж өгнө гэж хүлээхгүй байгаа.*  
*Алаг-Эрдэнэ сумын 1-р багийн малчинтай хийсэн ярилцлага*

500-аас дээш толгой малчин өрхийг төлөөлөх оролцогчдын хариултаас татвараа барагдуулахгүй байгаа шалтгаан тодорхой болохын зэрэгцээ тоо нь ч цөөрч байна. Тэд төлбөрийн эх үүсвэр, зохицуулалт хангалтгүй гэх мэт гомдол санал гаргадаггүй, харин баталгаатай өгөөж хүртэх, эсхүл татвар ногдуулалтыг бууруулах гол хүлээлттэй байдаг ажээ.




Б. ОЛОН МАЛТАЙ ӨРХ

Малын тооны бүлэглэл	Татвар төлөөгүй шалтгаан	Хувь
501-800 толгой малтай	Малчин өрх орлоготой байх үетэй татвар хураалт таардаггүй	33.3
	Татвар өндөр тогтоогдсон	20.0
	Малын тоог цөөлсний хариуд татварыг бууруулдаггүй	26.7
	Татвар төлсний өгөөж хүртэх баталгаа байхгүй	20.0
800-с олон малтай	Малынхаа тоог цөөлсний хариуд татварыг бууруулдаггүй	50.0
	Татвар төлсний өгөөж хүртэх баталгаа байхгүй	50.0

Асуумжаар тогтоохыг зорьсон анхаарал татсан гол асуудлын нэг нь татвар төлөгчид малынхаа тоо толгойг цаашид цөөрүүлэх бодолтой байгаа эсэх юм. Малын тоог цөөлөхдөө гэр бүлийн түвшинд шийдвэр гаргах, үүнд эмэгтэйчүүд тодорхой үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн үндэслэлээр хоёр хүйсийн төлөөллөөс асуумж авсан болно.

Дунджаар 80 хувиас давсан хариултаас үзвэл эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль аль нь малаа өсгөх бодолтой байгааг харууллаа. Үүнийг татвар ногдуулсантай холбох бус харин амьжиргааны амин чухал эх үүсвэр болох малаа өсгөж ирсэн стратегиас татгалзах хүсэлгүй байгаа гэж үзэх нь зөв юм.


ТАХИРМАГ 13. МАЛЫН ТООГ ЦӨӨЛӨХ ЭСЭХ, ЖЕНДЕРТЭЙ ХОЛБООТОЙ ХАНДЛАГА, ХУВЬ



Тун цөөхөн, тухайлбал асуумж өгсөн хоёр хүйсийн 10 хариулагчийн нэг нь татвар ногдуулсны хариуд малынхаа тоог бууруулна гэж хариулжээ.

Малын тоогоор дундажад орох малчин өрхүүд татварын дарамт хэр байхаас хамааруулан малынхаа өсөлтийг зохицуулна гэсэн бодолтой байгаа нь тэдний хариултаас харагдлаа.

ТАХИРМАГ 14. МАЛЫН ТООГ ЦӨӨЛӨХ ЭСЭХ, ХУВЬ




Асуумжид хамрагдсан малын тооны бүлгийг төлөөлсөн оролцогчдын ¾ гаруй нь мал сүргээ өсгөхөөс татгалзах бодолгүй байна гэж хариулжээ. Малын тооны бүлгийн хоёр туйл болох 100 хүртэл ба 800 ба түүнээс олон малтай бүлэгт хариултын хувь өндөр, харин дунд гурван бүлгийнх арай бага байна.

*Ерөнхийд нь хэлбэл, малчин өрхүүд малынхаа тоог аль хэдийнээ хэтэрсэн бэлчээрийн даацад нийцүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг зөөлрүүлэх, татварын дарамтыг зохицуулах хүсэл зорилго багатай байна гэж дүгнэж болохоор дүн асуумжаас гарлаа.*

Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүдийн тал хувь нь татварын мэдэгдэл хүлээн авсан эсэхээ мэдэхгүй гэж хариулжээ. Эрэгтэйчүүдийн хувьд энэ хариулт нэлээд өндөр, 73 хувьтай байна. Мэдэгдэл авсан хүн өрхийнхөө бусад гишүүддээ, түүний дотор эмэгтэйчүүдэд сайн танилцуулдаггүй, эсхүл эмэгтэйчүүд анхаарч танилцдаггүй явдал байгааг энэхүү өндөр үзүүлэлт хариулт харууллаа.

ТАХИРМАГ 15. 2023 ОНЫ ТАТВАРЫН МЭДЭГДЛЭЭ АВСАН ЭСЭХ, ХУВЬ



Мэдэгдэл хүлээн авснаа мэдээлсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь бараг адил, харин мэдүүлэг аваагүй эрэгтэйчүүд олон байна.

### 5.5.6 Татвар төлөх хандлага ба сэтгэл зүйн бэлэн байдал

Засгийн газрын тооцож байгаагаар МТТАТ орон нутгийн төсвийн орлогын нэг томоохон эх үүсвэр бөгөөд мал аж ахуйн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг сум өөрөө санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Малын тоо толгойн тухай албан татварын тухай хууль хэрэгжиж эхлээд дөнгөж хоёр жил өнгөрч байгаа ч Алаг-Эрдэнэ суманд татвар төлөлт сайн эхэлснээ дараа нь эрс буурсан. Татвар төлөгчид цаашид татвараа бүрэн төлөх эсэх нь ийнхүү эргэлзээтэй байдалтай байсантай холбогдуулан ногдуулсан татвараа төлөх хүсэл малчдын дунд хэр байгаа талаар сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтны үнэлэмжийг ярилцлага хийж тодруулав.

#### Хүснэгт 13. ТАТВАР ТӨЛӨХӨД ХАНДАХ ХАНЛАГА, ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ТӨРЛӨӨР

Татвар төлөгчид	Татвараа төлөхөд хэр ханддаг			Тайлбар
	Сайн	Дунд зэрэг	Хангалтгүй	
Малчин өрх			+	Хамгийн олон татвар төлөгчид
Мал бүхий этгээд			+	Сумын албан хаагчид, ажил эрхлэгчид, тэтгэврийн насны иргэд
Аж ахуйн нэгж		+		Хагас эрчимжсэн аж ахуй эрхлэгчид
Сумын харьяа байгууллагууд		+		Сумын сургууль, эмнэлэг, соёлын төв зэрэг цөөн малтай төсвийн байгууллага

Хэрэв татвараа 2021 оных шиг төлсөн бол үнэлгээ сайн гарах байсан боловч 2022 онд татварын хэмжээ эрс буурсан нь үнэлгээ өөрчлөгдөхөд хүргэлээ. Татварын байцаагч төлөх татварын хэмжээг тооцох, орлогыг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих, тайлагнах үүрэгтэй. Түүний үзэж байгаагаар татвар төлөгчид сайн мэдээлэлтэй байдаг ч гол асуудал нь татвараа төлөх хүсэл эрмэлзэл сул байгаа явдал ажээ.

#### Хүснэгт 14. ТАТВАРЫН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХ, ЗАРЦУУЛАХАД ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ОРОЛЦОО (СУМЫН ЗДТГ-ЫН АЛБАН ТУШААЛТНААС ӨГСӨН ҮНЭЛГЭЭ)

	Сайн	Дунд	Сул	Нэн сул
Татварын байцаагч			+	
Газрын даамал		+		
Хөдөө аж ахуйн мэргэжилтэн			+	
Хууль эрхзүйн мэргэжилтэн		+		

Малын тооны өөрчлөлт, бүртгэлийг хариуцдаг хөдөө аж ахуйн тамгийн мэргэжилтний үзэж байгаагаар малчид татвар төлөхдөө сул байна. Хуулийн мэргэжилтэн энэ үйл явцад шууд оролцдоггүй ч татвар төлөхдөө дунд зэрэг ханддаг гэж үздэгээ илэрхийллээ.

#### 5.5.7 Малын тоо толгойн албан татварт хандах хандлага: үзэл баримтлалын асуудлууд

“Global Financial Integrity” байгууллагын эх сурвалжид мэдээлснээр “хүмүүс татварыг өөрөөс нь гарч байгаа зардал гэж үздэг. Үнэн хэрэг дээр яг тийм биш. Бүх татвар төлөгчид өөрсдийн хувь нэмрээ оруулсан тохиолдолд хөрөнгө оруулалт болдог учиртай ажээ.

Татварын хэмжээ өндөр, хууль тогтоомж тодорхой бус, элдэв зөрчлөөс шууд урьдчилан сэргийлэх арга хэмжээ байхгүй гэх мэтээр татвараас зайлсхийх шалтгаан олон бий<sup>10</sup>.

Малчид татвараа төлөх хүсэл эрмэлзэлтэй, хамгийн гол асуудал бол татварын төлөгчдөд хэмжээг зөв тогтоох явдал нэн чухал хэмээн эх сурвалжууд дүгнэж байна<sup>11</sup>.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

### **МАЛЧИН ӨРХИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХУВААРЬ: ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХООРОНДЫН АЖЛЫН ЗОХИЦУУЛАЛТ**

Сонгодог онол ёсоор өрхийн хөдөлмөрийн хуваарь, гүйцэтгэж ирсэн үүрэгт гарсан өөрчлөлтийн хоорондын харилцан уялдаа болон өрхийн гишүүдийн ажил үүргийн хуваарь ямагт өөрчлөгдөн, шинээр зохицуулах шаардлагыг бий болгож байдаг уян хатан тогтолцоо юм. Гэхдээ эмэгтэйчүүдээс гэрийн ажилд их цаг зарцуулах, гэрийн гадуурх ажилд эрэгтэйчүүд илүү оролцдог тэрхүү онцлог хуваарь хадгалагдах замаар энэхүү уян хатан байдал, өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлж байна.

Эрэгтэйчүүдийн гүйцэтгэдэг ажлын хуваарь эмэгтэйчүүдэд ирэх гэрийн ажлын ачаалал, зарцуулах хугацаа нэмэгдэх өөрчлөлтийг сааруулахад төдийлөн тус багатай. Иймээс өрхийн хөдөлмөрийн хуваарийн судалгаа нь өрхийн хэмжээнд гүйцэтгэдэг ажил төрлийн хоорондын хамаарлыг хувиар илэрхийлэн тодорхойлоход чиглэгдэх ёстой ажээ.

Татвар төлөх эх үүсвэрийн талаар өрхийн түвшинд шийдвэр гаргах, түүнчлэн энэ зорилгоор мал борлуулах нь МТТАТ болон малчин өрхийн дотоод ажил төрлийн хоорондын бодит холбоог харуулж байж болох юм. Малын тоо нэмэгдэхийн хэрээр малын тооны бүх бүлгүүдээс арай олон мал борлуулах хандлага өсөх хандлагатай байна. Татвар төлөхдөө мал борлуулахын тулд өрхийн гишүүд малын төрөл зүйл, тоо, хэдийд борлуулах талаар ярилцаж зөвшилцөх ёстой. Мал бол хувь хүний өмч биш өрхийн дундын өмч учраас аливаа төрлийн малыг борлуулсны орлогыг өрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.

Өрхийн малыг дийлэнхдээ нөхрийнхөө нэр дээр тоолуулдаг, албан ёсны бүртгэлтэй байдаг. Өрхийн шийдвэр гаргалт, өмчлөлийн асуудал, нэн ялангуяа дундын өмчлөлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна.

Өмчлөх эрхийн бичгийг зөвхөн өрхийн аль нэг гишүүний нэр дээр олгодог өнөөгийн практик нь өмчийн эрх мэдлийн тэгш бус байдлыг бий болгож<sup>12</sup>бусад гишүүдийн зөвшөөрөлгүйгээр малыг худалдах зэрэг тэгш бус байдал аяндаа гарахад хүргэдэг ажээ.

---

<sup>11</sup><https://gogo.mn/r/gqo1w>

<sup>12</sup> <https://pastoralismjournal.springeropen.com/articles/10.1186/s13570-021-00220-6>

Энэ байдлыг засаж залруулахын тулд хамтран өмчлөх эрхийг дэмжсэн хууль эрх зүйн орчны талаар малчин өрхийн гишүүдэд ойлголт өгөх, мэдээллээр хангах шаардлагатай<sup>13</sup>.

Зорилтот сумын малчин өрхийн гишүүдтэй хийсэн ярилцлагаар гишүүд нь өрхийн ажил хөдөлмөрийн хуваарьт үүргээ хэрхэн гүйцэтгэдэг, хөдөлмөрийн ачаалал жилийн туршид хэрхэн өөрчлөгддөг талаар ерөнхий болон нарийвчилсан мэдээлэл авлаа. Малчин өрхийн тэргүүн, эзэгтэй, бусад гишүүдийн хөдөлмөрийн хуваарь, ачааллыг тус тусад нь тахирмагаар дүрслэн үзүүлэв. Өрхийн хэмжээнд хийх ажлыг гэрийн, гэрийн гадуурх, түүнчлэн тухайн үеийн шаардлагаар гарч ирдэг буюу өрхийн шийдвэр гаргах, маркетинг болон хамтран гүйцэтгэх хэмээн ерөнхийд нь ангиллаа.

Хүснэгт 15. Малчин өрхийн хөдөлмөрийн хуваарь, гишүүдийн оролцоо, Алаг-Эрдэнэ сумын жишээ

Үндсэн ажил, үйлдэл	Өрхийн гишүүдийн оролцоо		
	Нөхөр	Эзэгтэй	Бусад гишүүд
<b>Бүх улиралд хийдэг гэрээс гадуур ажил</b>			
1. Мал хариулах:			
• Бод мал	+++	+	+
• Бог мал	+++		+
2. Төл, өсвөр малын арчилгаа	+	++	+++
3. Мал тэжээх ба эмчилгээ	+	++	++
4. Мал услах	+++		
5. Малын хашааны бууц цэвэрлэх, овоолох	++	+	++
6. Түлшний мод бэлтгэх, тээвэрлэж авчрах	+++		
7. Бог мал төллөлт	+++	+++	++
8. Үнээ тугалалт		+++	
9. Гүү унагалах	+++		+
10. Адуу дэллэх	+++	+	+
11. Үнээ саах		+++	+
12. Бог малын сааль ашиглалт		+++	+
13. Сүү боловсруулах, цагаан идээ хийх		+++	+
14. Ямаа самнах	++	++	++
15. Хадлан хадах, өвс хатаах, хураах	+++	+	+
16. Гар тэжээл бэлтгэх		+++	+
17. Нүүдэл (гэр, бусад эд агуурс)	+++	+	
18. Малын хашаа, саравч засах	+++		
19. Өтөг бэлдэх	++		+
20. Өвлийн түлш бэлтгэх	+++		+
21. Хонины нэхий элдэх		+++	
22. Үхрийн шир боловсруулах, суран эд зүйлс хийх	+++		+
23. Эсгий хийх	++	++	++
<b>Бүх улиралд хийдэг гэрийн ажил</b>			
1. Хоол унд бэлтгэх		+++	+
2. Гэр цэвэрлэх		++	+
3. Угаалга		+++	
4. Оёдол		+++	
5. Сүү цагаан идээ		+++	+
6. Хүүхэд асрах	+	+++	++
<b>Хамтын ба хүйсний хамаарал бүхий шийдвэр гаргах</b>			

<sup>13</sup> <https://pastoralismjournal.springeropen.com/articles/10.1186/s13570-021-00220-6>


1. Мал худалдах			
1.1 Адуу	+++		
1.2. Үхэр	++	++	
3. Бог мал		++	
4. Гулуузалсан мах худалдах	+++	+	
5. Хоолуур ноос худалдах	++	++	
6. Сүү, цагаан идээ худалдах		+++	
7. Тэжээл худалдаж авах	+	++	
8. Ахуйн зүйлс худалдаж авах	+	+++	+
<b>Өрхийн хэмжээний тусгай ажил, арга хэмжээний зохицуулалт (өрхийн гишүүд тусдаа байх - сургуулийн хүүхэдтэйгээ сумын төвд сүүх гэх мэт)</b>			
1. Сургуулийн бага насны хүүхэд (сургуулийн хүүхэд харах)		+++	+
2. Гэр, малаа харах	+++	+	+
3. Хурдны морь сойх	+++		+
4. Татвар төлөх эх үүсвэр, хөрөнгө бий болгох	++	++	
5. Хамаатан, найз нөхдийндээ айлчлах, уулзах	++	+	+
6. Янз бүрийн ёслол, үйл ажиллагаанд оролцох (хурим, наадам, соёл урлагий арга хэмжээ гэх мэт)	++	++	+

Тэмдэглээ: (+++ -бүрэн, ++ - хагас, + бага оролцдог

Асуумжид хамрагдсан өрхийн бүх гишүүдийн тайлбарласнаар хийх ажил, хийх ёстой ажлуудыг ажлын төрөл, гишүүдээр нь ялгаж, оролцооны түвшинг зэрэглэлээс хамааруулах нь зүйтэй гэж үзлээ.

**А.Эрэгтэй гишүүн (нөхөр).** Өрхийн эрэгтэй гишүүд гадуурх ажлын гол хүч бөгөөд гэрийн ажилд тодорхой хэмжээгээр оролцдог. Тахирмагаас үзвэл эрэгтэйчүүд жилийн аль ч улиралд гадуурх ажилд асар их үүрэг оролцоотой бөгөөд жилийн хатуу ширүүн, тааламжгүй үе болох хавар, бүх өрх өвөлжилтийн бэлтгэл ажил хийдэг - хадлан бэлтгэх, отор нүүдэл хийх, өвөлжөө хаваржаагаа засах ажилд шамддаг намрын улиралд, түүнчлэн өвөл-хаврын улиралд мал хариулах, мал төллөх ажилтай уялдан ачаалал нэмэгддэг гэсэн дүрслэл харагдаж байна.


ТАХИРМАГ 16. ӨРХИЙН ЭРЭГТЭЙ ГИШҮҮН (НӨХӨР)-ИЙ АЖЛЫН АЧААЛАЛ



Бог мал төллөлт, ямаа самнах хамгийн хүнд, ажил нэлээд шаарддаг хоёр ажилд эрэгтэй гишүүд нэлээд оролцдог учраас тэдний ажлын ачаалал хаврын улиралд нэмэгдэхэд хүрдэг.

**Б.Эмэгтэй гишүүн (эзэгтэй).** Эзэгтэйн хувьд тэд аль ч улиралд гэрийн ажилд илүү, онцгой хариуцлага хүлээдэг, шууд оролцдог бөгөөд хаврын улиралд гэрийн гадуур ажил тодорхой хэмжээгээр нэмэгдэж ирдэг. Өвөл, зун эзэгтэй их төлөв гэртээ байж, боловсруулах, оёх, хувцас хийх зэрэг гэр бүлд хамаарах олон ажлыг хийдэг.

ТАХИРМАГ 17. ГЭРИЙН ЭЗЭГТЭЙН АЖЛЫН АЧААЛАЛ




Гадуурх ажилд эмэгтэйчүүдийн оролцоо буурч байгаа нь өрх доторх хүйсийн онцлогт тохирсон хөдөлмөрийн хуваарийн онцлогийг тодорхой харуулж байна. Хавар, намар бол эмэгтэйчүүд гадуурх болон гэрийн ажлын нэлээд их ачаалалтай байдаг улирал юм. Өвлийн улиралд бусад улиралтай харьцуулахад эмэгтэйчүүдийн ачаалал багавтар байгаа нь гайхширах зүйл биш, учир нь ихэнхдээ эзэгтэй нь сургуулийн хүүхдүүдээ “харахаар” сумын төв болон бусад төвлөрсөн суурин газруудад нүүж, удаан хугацаагаар оршин суудагтай холбоотой.

**В.Бусад гишүүд.** Айл болгон эхнэр, нөхөр хоёрын төрсөн болон хадам эцэг эх, гээд насанд хүрсэн ахмад настан, хүүхдүүд байдаг. Ажлын ачааллын хувьд тэд тодорхой хувь нэмэр үзүүлдэг, хамгийн хэрэгтэй тусламжийг тодорхой хугацаанд буюу ихэвчлэн зун, намрын улиралд сургуулийн хүүхдүүд амарч, ахмадууд гадуурх ажилд хүртэл оролцдог.

ТАХИРМАГ 18. ӨРХИЙН БУСАД ГИШҮҮДИЙН АЖЛЫН АЧААЛАЛ





Настайчууд, хүүхдүүд гэрийн ба гадуурх ажилд оролцох, туслахад хамгийн тааламжгүй улирал гэвэл өвөл, хаврыг хэлж болно. Өмнөх оны есдүгээр сараас дараа оны тавдугаар сарын сүүл хүртэл хүүхдүүд сургуульд 9 сар гаруй суудаг. Энэ үеэр өвөл-хаврын хүйтэнд өртөх эрсдэлтэй ахмад настнууд ч гэсэн гадуурх ажилд оролцох нь багасдаг үе.

Харьцуулах үүднээс хэлэхэд, Африкийн орнуудад тарих, хураах, цэвэрлэх гэх мэт тариалангийн ажлын 70 хувийг эмэгтэйчүүд гүйцэтгэдэг. Түүнээс гадна хүүхэд, гэр орон, нөхөр, өөрийгөө халамжлах ёстой. Бүтээх, үйлдвэрлэх, боловсруулах, түгээлтийн түвшинд эмэгтэйчүүд маш хүнд ажил хийдгийг бид мэднэ, гэтэл өрх, орон нутаг, бүс, муж улсын түвшинд шийдвэр гаргах ажиллагаанд тэд тэргүүн суудалд сууж байхыг хардаггүй нь хачирхалтай, бас сонин. Энэ тайлбарт хариу хэлэхэд, Монголын мал аж ахуйн тогтолцоо нь цэвэр бэлчээрийн мал аж ахуй бөгөөд харин нүүдэлчин биш гэдгийг тодорхой хэлэх хэрэгтэй. Иймээс манай улсын мал аж ахуйн тогтолцоо нь засаг захиргааны болон улирлын чанартай бэлчээрийн тодорхой хил хязгаартай, байнгын өвөлжөө, хаваржаатай, зун-намрын улиралд нутаглах бэлчээр нутагтай, иймээс Монгол орны хувьд ийм харьцуулалт зөв хандлага биш. Малаа байнга хариулгатай байлгах, алдагдахаас сэргийлэх, махчин амьтдаас хамгаалах гээд олон хүнд ажлыг эрэгтэйчүүд хийдэг бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд гэрийн ажил зонхилдог. Өрхийн доторх жендерийн онцлогтой өрхийн хөдөлмөрийн хуваарь, ачаалал нь МТТАТ-ын асуудалд чухал биш, орлогыг удирдах, түүнийг захиран зарцуулахтай холбоогүй гэдгийг ойлгох нь зүйтэй.

Малчин өрхөд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарь, ажлын ачаалал тодорхой хэмжээгээр ялгаатай, эмэгтэйчүүд ихэвчлэн бүтээх ба боловсруулах хүнд ачааллыг үүрдэг. Харамсалтай нь, шийдвэр гаргах үйл явц, өрхийн менежмент, олон нийтийн оролцоо, манлайлалд эмэгтэйчүүдийн оруулж буй үлэмж хувь нэмрийг үл тоомсорлодог явдал цөөн бус тохиолддог.

Энэ байдлыг залруулж, жендерийн тэгш байдлыг хангахын тулд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаарх мэдлэгийг цаашид улам гүнзгийрүүлэх, бодит байдлын мэдээллийг сайжруулахад эн тэргүүнд анхаарах ёстой. Санхүүгийн асуудлаар болон өрхийн шийдвэр гаргахад оролцоо, чадавхжуулах, үр ашгийн дүн шинжилгээ,

нягтлан бодох бүртгэл, өрхийн санхүүгийн бүртгэл зэрэг практик ур чадвар, хэрэгслээр хангах нь нэгэн адил чухал юм. Мөн чанартаа эдгээр арга хэмжээ нь жендерийн тэгш байдлыг тэнцвэржүүлж, эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрч, үнэлгээжүүлэх, өрхийн үйл амьдралд эмэгтэйчүүд идэвхтэй хувь нэмэр оруулж, үр шимийг нь хүртэх боломжийг хангах зорилготой юм.

Нөхөр, эзэгтэй хоёулаа бүтээх ажлаа хамтран гүйцэтгэдэг жишээг тусгайлан зориуд судалж сурталчлах нь уламжлалт жендерийн үүргийг илүү тодруулж эерэг үлгэр жишээ болох учиртай нэмж хэлэх хэрэгтэй<sup>14</sup>.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

### МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ (GLEAM)-ЫГ АШИГЛАН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ОДООГИЙН БАРИМТАЛЖ БҮЙ БОЛОН ИРЭЭДҮЙД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АРГА БАРИЛААС ҮҮДЭЛТЭЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ ҮНЭЛСЭН ДҮНГЭЭС

#### 7.1 Хөдөө аж ахуйн салбарын хүлэмжийн хийн ялгарал

1990 оноос хойш хөдөө аж ахуйн салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгарал тасралтгүй нэмэгдэж байгаа нь малын тоо толгойн өсөлттэй шууд холбоотой. Хөдөө аж ахуйн салбараас ялгарах нийт хүлэмжийн хийн 57.3 хувь нь хивэгч амьтадаас ялгарах метан хий, 41.17 хувийг нүүрс хүчлийн давхар ислээс бусад хийн хольц, 1.5 хувийг бордооноос ялгарах метан хий эзэлж байна.

Хөдөө аж ахуйн салбартай холбоотой хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндсэн арга хэмжээ нь<sup>15</sup>:

- Малын тоо толгойн өсөлтөд хяналт тавих,
- Малын бууцны менежментийг сайжруулах,
- Бэлчээр, хөрсийг хамгаалах, болон
- Малын тоог бууруулахад тус тус чиглэгдэнэ.

Малын тоог бууруулах зорилгод хүрэхийн тулд дараах хувилбаруудыг анхаарч байна<sup>16</sup>.

1. Малчдын малаа өсгөх сонирхол, хандлага тодорхой хугацаанд үргэлжилж, малын тоо толгой жилд 0.5 хувиар өснө. Дэлхий даяар 2030 он гэхэд малын тоо хоёр дахин өснө. Монгол Улсын үндэсний оруулах хувь нэмрээс харахад хүлэмжийн хийн ялгаруулалтын 2010 оны түвшин 25.8 сая тонн CO<sub>2</sub>-экв байсантай харьцуулахад 2.76 дахин нэмэгдэж, 74.2 сая тонн CO<sub>2</sub>-экв болно гэж таамаглаж байна.

<sup>14</sup>file:///C:/Users/97699/Downloads/AFS\_Gender\_Pastoral\_2015\_Mongolia%20(3).pdf

<sup>15</sup> /https://www.mongolbank.mn/file/682196b674474a383e3b756cd53171d9/files/MB\_33\_last-41-57.pdf

<sup>16</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210340&showType=1>

2. НҮБ-ын ХХААБ-аас үндэсний түвшинд гаргасан зөвлөмжийн дагуу бэлчээрийн даацын 2015 оны статистикийн мэдээнд үндэслэн малын тоог жилд 5 хувиар цөөлөх.

3. Монгол Улсын ХХААХҮЯ-ны тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөрт заасанчлан малын тоо толгойг үе шаттайгаар бууруулж 2033 онд хонин толгойд шилжүүлснээр 74 сая толгой, өөрөөр хэлбэл 51.2 сая толгой малтай болохоор тусгасан.

Мал аж ахуйн салбар уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Хүлэмжийн хийн ялгарлын 14.5 хувь нь мал аж ахуйн салбараас хамааралтай байдаг байна. Мал аж ахуйн салбар нь жилд 7.1 гига тонн нүүрстөрөгчийн давхар исэлтэй дүйцэхүйц хэмжээний хий ялгаруулдаг.

Хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг салбар тус бүрээр хэрэгжүүлснээр 2030 онд хүлэмжийн хийг бууруулах нийт хэмжээ 16.89 сая тонн CO<sub>2</sub>-экв болно. Энэ бууралтын 31.3 хувийг хөдөө аж ахуйн салбараас бууруулах боломжтой. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг системтэй хэрэгжүүлснээр Монгол Улсын хэмжээнд ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлын нийт хэмжээг 52.32 сая тонн CO<sub>2</sub>-экв-д хүргэх боломжтой, 2025 онд 57.36 сая тонн CO<sub>2</sub>-экв болно.

Монгол улсын тогтвортой мал аж ахуйн 2018 оны хөтөлбөр нь 2018 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо зохиогдсон Дэлхийн тогтвортой мал аж ахуйн 8 дугаар хуралдааны хүрээнд боловсруулсан баримт бичиг юм. Уг хөтөлбөрт бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, хүнсний аюулгүй байдал, нийгмийн хүртээмжийг нэмэгдүүлэх, оролцогч талуудын түншлэл, оролцоог бэхжүүлэх зэргийг тусгасан.

Монгол улсын тогтвортой мал аж ахуйн 2018 оны хөтөлбөрийн зорилго нь:

1. Бэлчээр, усны нөөцийг нөхөн сэргээх, ашиглах, тогтвортой, хариуцлагатай хандах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах;

2. Малын төрөл бүрийн бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, ашиг шимийг дээшлүүлж, экспортод чиглэсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

3. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах;

4. Хөдөөгийн хөгжлийг дэмжих, ядуурал, орлогын тэгш бус байдлыг бууруулах, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах;

5. Мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, малчдын байгууллага, хоршоо, олон улсын байгууллага зэрэг оролцогч талуудын түншлэлийг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих.


## 7.2 GLEAMi-г туршсан дүн

Мал аж ахуйн салбарын хүрээлэн буй орчны үнэлгээний загвар (GLEAM) ашиглан 1) үхэр (бэлчээр, холимог тэжээл), 2) бусад хивэгч (бэлчээрийн болон холимог тэжээл) 3) гахай (өрхийн, хагас эрчимжсэн, үйлдвэрлэлийн), тахианы (өрхийн, үйлдвэрлэлийн) эрчимжсэн аж ахуйн 3 системд ангилдаг. Мөн агроэкологийн –хувьд сэрүүн бүс нутаг, халуун орны өндөрлөг газрыг хамрах сэрүүн бүс, хуурай ба хагас хуурай тропикийн болон субтропик

хамарсан хуурай бүс нутаг, чийглэг тропикийг хамруулсан чийглэг бүс нутаг гэсэн 3 үндсэн бүсээр ангилдаг. Тооцоололд сүргийн бүтэц, тэжээл, төрөл зүйлийн тодорхой үзүүлэлтүүдийг ашигладаг. Энэхүү загвар нь тэжээлийн хэрэглээ болон агро-экологийн нөхцөлд үндэслэн тооцоолол гаргадаг.

### 7.2.1 Модулын тооцоолол

GLEAM-ийн бүтэц нь малын тоо толгой, өтөг бууц, тэжээл, систем ба хуваарилалт гэсэн үндсэн 5 модулиас бүрдэх ба фермийн эрчим хүчний шууд ба шууд бус хэрэглээ, фермийн цааших нөлөөллийг тооцох нэмэлт 2 модулиас бүрдэнэ. Үүлдрийн чанар, тэжээлийн эх үүсвэр, хүртээмжийн хувьд Монгол орны өвөрмөц онцлогийг харгалзан өнөөгийн нөхцөл байдлыг (одоогийн хувилбар) хамгийн сайн батлах модулиудыг сонгосон. Эцсийн сонголтод сүрэг (нутгийн үхэр, бог мал) болон тэжээл (бэлчээрийн ногоо ба хагд, хадлангийн өвс) модулиудыг багтаасан бөгөөд ингэснээр системийн модулийн хувьд хүлэмжийн хийн ойролцоо тоонуудыг тооцоолох боломжтой болно.



Хүснэгт 16. БЭЛЧЭЭРИЙН МАЛЛАГААТАЙ ҮНЭЭ

Систем	Чиглэл	Нас	Үзүүлэлт	Нэгж	Суурь	Алаг-Эрдэнэ сумын мэдээ суурь	Алаг эрдэнэ сум, 2023
Бэлчээрийн	Мах	Нас гүйцсэн үнээ	Бэлчээрийн ногоо	%	2.31	39	39
Бэлчээрийн	Мах	Нас гүйцсэн үнээ	Хагд	%		41	41
Бэлчээрийн	Мах	Нас гүйцсэн үнээ	Хадлан	%	1.74	20	20

### 7.2.2 Монгол малын хүлэмжийн хийн ялгарлыг бусад орнуудаас ялгаатай болгож буй хүчин зүйл, нөхцөл байдал

Монголын нөхцөлд хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэрүүд болон тэдгээрийн нийт хий ялгаруулалтад оруулсан хувь нэмэр нь дэлхийн бусад олон улстай адилгүй өвөрмөц онцлогтой: Үүнд:

Монгол орны бэлчээрийн ургамал ургалтын хугацаа харьцангуй богино, 6-р сарын 10-аас 9-р сарын эхний 10 хоног хүртэл үргэлжилдэг. Зун бол бэлчээрийн ургамлаар хүлэмжийн хийн шингээлт явагддаг цорын ганц улирал юм. Зун эхлэхээс өмнө бэлчээрийн тэжээлийн нөөц бүхэлдээ хатсан, фотосинтезийн процесс огт байхгүй хуурай хагд хэлбэрээр хадгалагдана. Зуны эцэс гэхэд бэлчээрийн ургамлын бараг 90 хувь нь хатаж үлдсэн үнэрт болон идэмжээр төдийлөн сайнгүй зүйл ургамал бага зэрэг чийгтэй үлддэг. Ногоон ургамлаар дамжуулан хүлэмжийн хийг идэвхтэй шингээх хугацаа 3 сар гаруй үргэлжлэх бөгөөд зуншлага сайн жилүүдэд урт буюу 100 орчим хоног үргэлжилдэг. Ургамал ургалтын үеийн тэжээлийн хуримтлал, өвөл-хаврын улиралын турш дахь хадгалалт нь цаг уурын хэвийн жилүүдэд доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн харьцангуй тогтмол байна.

ХҮСНЭГТ 17. БЭЛЧЭЭРИЙН УРГАЦ ХАДГАЛАЛТ, САРААР

Байгалийн бүс бүслүүр	Бэлчээрийн ургац хуримтлал, зуны дээд ургацтай харьцуулсан хувь					Бэлчээрийн хагдралт, ургац бууралт, зуны дээд ургацтай харьцуулсан хувь						
	Хуанлийн сар					Хуанлийн сар						
	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	IV	V
Өндөр уул	у*	у*	9.0	89.7	100	78.9	65.7	62.6	60.4	53.2	43.3	40.7
Ойт хээр	у*	33.1	44.7	76.6	100	80.5	67.6	60.9	53.2	49.1	42.1	23.2
Хээр	у*	19.1	60.8	9.2	100	87.4	77.3	62.3	61.8	50.7	48.9	х*
Цөлөрхөг хээр	12.2	43.1	59.2	69.2	100	86.5	65.1	62.9	55.1	41.0	х*	х*

х\* шинэхэн өвс ургаснаар тэжээлийн хуримтлал эхэлдэг

у\* 4 болон 5 сард ижил

1. Хавар, зун, намар, өвөл хэмээх 4 улирал ээлжлэн солигдохыг даган бэлчээрийн ургамлын гарц, шим тэжээлийн чанар тодорхой хэмжээгээр буурч байна.

2. Бэлчээрийн бүтээмж, ургац хамгийн өндөртэй тал хээр, ойт хээр, тайгын бэлчээрийн хөрс 10-р сарын дунд үеэс 4-р сарын дунд үе хүртэл ойролцоогоор 6 сар буюу хагас жилтэй тэнцэх хугацаанд гүн хөлддөг. Цасан бүрхүүлтэй хөлдүү хөрс нь хүлэмжийн хийг ялгаруулахгүй.

3. Хонины тэжээлийн дутагдал нь жилийн тэжээл хангамжийн 42-46 орчим хувийг эзэлдэг, өөрөөр хэлбэл, бараг хоёр дахин бага тэжээл хэрэглэдэг түүнийг даган хүлэмжийн хийн ялгарал ч мөн буурна. .

4. Тэжээлийн дутагдлын улмаас хүйтний улиралд нутгийн мал амьдын жин дунджаар 20%-иар буурдаг тул үүнийг даган хүлэмжийн хийн ялгарал мөн буурах магадлалтай.

5. Хатсан өвс, хагд нь хүлэмжийн хийг багахан хэмжээгээр шингээж мөн багахан хэмжээгээр ялгаруулдаг байж болох юм. Тиймээс хүйтний улиралд хагдан бүрхэвчээс хүлэмжийн хийн ялгаралд бодитой хэмжээнд нөлөөлдөггүй.

6. Хүйтний улиралд бог малын бэлчээрт ялгасан бага үлдээж харин амрах, хивэх, бууц руугаа буцах үед аргал их хуримтлагддаг. Бууцны хөлдүүс хавар дулаартал хөлдүүгээрээ хадгалагддаг.

7. Адууны хомоол, үхрийн баас хавар дулаартал хөлдсөн хэвээр байна. Зун, намрын улиралд үхэр, адууны аргал, аргал ялаа, шувуудын нөлөөгөөр хэмжигдэхүйц хэмжээний хий ялгарахаас өмнө шууд богино хугацаанд задардаг.

### 7.3 GLEAMi-ны туршилтын дүн

GLEAM-i, хүрээлэн буй орчны хүлэмжийн хийн ялгаруулалтын үнэлгээ, загварчлалын хэрэгсэл нь мал аж ахуйн салбарын онцлогт тохируулсан, олон нийтэд нээлттэй, хэрэглэгчдэд ээлтэй шийдэл болж, засгийн газар, төсөл төлөвлөгчид, үйлдвэрлэгчид, үйлдвэрүүд болон иргэний нийгмийн байгууллагуудад IPCC Tier 2 аргыг ашиглан хүлэмжийн хийн ялгаруулалтыг үнэн зөв тооцоолох явдал юм. Энэ нь хүлэмжийн хийн үндэсний тооллого, төслийн өмнөх суурь түвшинг тодорхойлж бэлтгэхэд үнэлж баршгүй чухал ач холбогдолтой бөгөөд мал аж ахуй, тэжээлийн менежмент, өтөг бууцтай харьцах арга хэмжээний хувилбаруудын талаарх ойлголтыг санал болгож, улмаар мал аж ахуйн салбарын салбартай холбоо бүхий хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах талаар шийдвэр гаргах, бодлого боловсруулахад тус дөхөм болж, хөдөө аж ахуйн ландшафтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх чухал алхам болно.

Алаг-Эрдэнэ сумын 2022 оны мал тооллогын мэдээг ашиглан хүлэмжийн хийн ялгартыг тооцох зорилгоор GLEAMi-г турших туршилтыг үхэр, хонь, ямаа гэсэн 3 төрлийн мал дээр менежментийн 7 хувилбар бүхий туршилт тавилаа (Хавсралт 3).

Үхрийн "зохистой сүргийн бүтэц" гэсэн нэр томьёо нь сүргийн бүтэц дэх өөр өөр хандлагыг илэрхийлдэг бөгөөд энэ нь төрөд бүрийн малын тооны хоорондын харьцааг сайжруулах зорилготой юм. Энгийнээр хэлбэл, хээлтэгчийн эзлэх хувийг нэмэгдүүлэх замаар сүрэг доторх хээлтүүлэгч болон сувай малын эзлэх хувийг бууруулна гэсэн үг.

Үхрээс ялгарах хүлэмжийн хийн хэмжээг дараах хувилбараар тооцооллоо.

А. Тэжээлээр хангах дор дурдсан хувилбар бүхий малын оновчтой бүтэц /бэлчээрийн шинэ ногоо 39%, хагд өвс 41%, хадлангийн өвс 20%

1. Сүргийн одоогийн бүтэц (суурь)
2. Малын тоо толгойг жил бүр таван хувиар бууруулах
3. Малын тоо толгойг жил бүр зургаан хувиар бууруулна
4. Малын тоо толгойг жил бүр долоон хувиар бууруулна

Б.Сумын мал /тэжээлийн хангамж: бэлчээрийн ногоо 39%, өвс 20%, хог 41%/

1. Сүргийн одоогийн бүтэц (суурь);
2. Малын тоо толгойг жил бүр таван хувиар бууруулах
3. Малын тоо толгойг жил бүр зургаан хувиар бууруулна
4. Малын тоо толгойг жил бүр долоон хувиар бууруулна

#### 7.3.1 Туршилтын үр дүн

GLEAMi загварын өгөгдмөл загвартай харьцуулбал малын тоо толгойг бууруулснаар хүлэмжийн хийн ялгаралт багасах эсэхийг тодорхойлохын тулд хэд хэдэн тооцоолол хийсэн.

**Сүргийн зохистой бүтэц** гэдэг бол үржлийн насны хээлтэгчийн хувийн жин 45-48 хувь, сүрэг сэлбэх өсвөр үхэр 20 орчим хувь, тухайн жилийн төл мөн 20 орчим хувь, үржлийн



хээлтүүлэгч 3-5 хувь, бусад 10 орчим хувь байхыг хэлдэг. Сүргийн зохистой бүтцээр нийт 10861 толгой үхэртэй.

Зохистой бүтэц бүхий сүргийн малын тоог цөөлөхөд хүлэмжийн хийн ялгарлыг одоогийнхоос (сүргийн бүтэц нь алдагдсан) илүү бууруулах боломжтой гэсэн ерөнхий дүгнэлт хийж болох юм. Өөрөөр хэлбэл, сүргийн бүтцийг зохистой харьцаанд барих нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нэг хувилбар мөн. Сүргийн зохистой бүтэцтэй мал сүргийн хүлэмжийн хийн ялгаралтын нийт бууралт (суурь хувилбар тогтмол хэвээр) ойролцоогоор 22.5% болсон байна. Суурь үзүүлэлттэй харьцуулахад үхрийн тоог бууруулах гурван хувилбарт хүлэмжийн хийн ялгаралт малын тоог 5%-иар бууруулахад 21.4%-иар, малын тоог 6%-иар бууруулахад 20.3%-иар, малын тоог 7%-иар бууруулахад 19.2%-иар тус тус буурсан.

ТАХИРМАГ 20. ҮХРИЙН ТООГ ТОДОРХОЙ ХУВИАР ЦӨӨЛӨХӨД ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БУУРАХ



2023 = 2002 оны мал тооллогын мэдээгээр тооцсон:  
GLEAM-ийн суурь үзүүлэлтийг 100 хувиар авав

Сүргийн энгийн нөхөн үйлдвэрлэлийг хадгалах болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах шаардлагыг харгалзан үзвэл үхрийн тоог 6 хувиар бууруулах хувилбар оновчтой байна.

Малын тоог жилд 8 хувиас илүү цөөлөхөд малчин өрхийн орлого буурах сөрөг үр дагавартай тул малын тоог цөөлөх болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах харилцан уялдаа бүхий зорилтыг хангах хувилбар нь 5-6 хувь байх үндэслэлтэй.

Нөхөн үржихүйн сүргийн бүтцийг хадгалах хэрэгцээ, хүлэмжийн хийн хэмжээг бууруулах хэрэгцээ шаардлагаас харахад 6%-иар бууруулах хувилбар зөв харагдаж байна. Зарим эх сурвалжийн мэдээлснээр сүргийн тоо толгойг жил бүр 8-аас дээш хувиар цөөлөх нь малчин өрхийн орлого буурах сөрөг нөлөөтэй тул малын тоог бууруулах, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгахад дээр джрдсан 5-6 хувийг сонгох нь оновчтой хэмээн зөвлөж байна.

### Алаг-Эрдэнэ сумын үхэр сүргийн тооцоолол

Алаг-Эрдэнэ сум 2022 онд 10861 толгой үхэр тоолуулсан бөгөөд энэ нь 21-р зурагт үзүүлсний дагуу хүлэмжийн хийн бууралтыг гурван хувилбараар тооцлоо. Үхэр (цаашид сүрэг гэх)-ийн тоо толгойг бууруулах хувилбарууд нь хүлэмжийн хийн бууралттай шууд холбоотой. Малын тоо цөөрсөн нь хүлэмжийн хийн ялгаралтад нөлөөлж 0.2-0.9%-иар бууруулж болохыг харуулж байна.

ТАХИРМАГ 21. ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ, 3 ХУВИЛБАРААР, ХУВЬ



Тус сумын үхэр сүргийн хүлэмжийн хийн ялгарал буурсан нь сүрэгт эзлэх хээлтэгчийн хувийн жинг нэмэгдүүлж, нас гүйцсэн эр үхрийнхийг бууруулах дунд хугацааны стратегитэй нийцэж байгаа бөгөөд яваандаа нөхөн үржихүйн үр ашгийг дээшлүүлэхэд зохих нөлөө үзүүлнэ.

#### 7.4 RECISOIL: тоо мэдээ цуглуулсан байдал

RECISOIL, Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх зорилго бүхий санаачилга нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх орон нутгийн санаачлагыг дэмжин ажилладаг.

Газрын тогтвортой менежмент, ойжуулалт, нөхөн сэргээлт зэрэг олон талт хамтын ажиллагаа нь нүүрстөрөгчийн шингээлтийг урамшуулах бодлогын баримт бичиг боловсруулах орон нутгийн чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.

Холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх болон олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан

RECISOIL нь хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг дэмжих замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь үйл ажиллагааг өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байна.

Судалгааны дүнгээс харахад хөрсний химийн найрлага нь сул шүлтлэг урвалын орчинтой. Цахилгаан дамжуулах чанар сул, давсжилт багатай. Хөрсөн дэх карбонатын агууламж бага буюу тохиромжтой түвшинд байна. Хөрсний 0-20 см давхаргад ялзмагийн агууламж зохих түвшинд байна. Ургамалд ашиглагдах фосфор, калийн хэмжээ хангалттай. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд дунд шавранцар хөрстэй. Шавранцар хөрс нь элсэрхэг, шаварлаг хөрсний хооронд байх ба чийг, агаар, дулааны горим сайн байдаг. Ус чийг нэвтрүүлэх чадвар сайтай учир гадаргуу дээр ус тогтдоггүй давуу талтай. Хөрсний үржил шимийн түвшин сайн байна.

Монгол орны хойд талыг хамарсан хүйтэн, чийглэг бүс нутаг дахь хүлэмжийн хийн ялгаруулалт, шингээлтийг RECSOIL загвараар тодорхойлох зорилгоор Дэлхийн хүнс, ХАА-н байгууллагаас боловсруулсан аргачлалын дагуу мэдээлэл цуглуулж холбогдох боловсруулалтыг хийгээд байна.

Өнөөдрийн байдлаар газрын харилцааны (5100 цэг) болон ус, цаг уурын (1500 цэг) улсын сүлжээ нийт 6600 цэгийг хамарсан мэдээллийн сантай, бэлчээрийн экосистемийн өөрчлөлт, бэлчээр ашиглалтын нөлөөг үндэсний түвшинд үнэлэх урт, богино хугацааны мониторингийн 2 хөтөлбөр хэрэгжиж байна.

Бэлчээрийн экосистемийн үйл ажиллагаа, экологийн чадавхийг үндэслэн ойт хээрийн бүсийн төлөөлөл Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд 3 үндсэн цэг дээр үнэлгээ хийлээ. Аргол БАХ нь дөрвөн улирлын 23,145 га бэлчээртэй. Олон жилийн дундажаар 300 мм–350 мм тунадас унадаг.

Алаг-Эрдэнэ сумын Аргол БАХ-ын нутаг дэвсгэрт WRB хөрсний ангиллаар

- o Аллювийн нуга-намгийн ширэгт глейт хөрс
- o Уулын хүрэн хөрс
- o Уулын хар хүрэн хөрс гэсэн 3 төрлийн хөрс тархсан байна.

Бэлчээр ашиглалтыг харгалзуулан хөрсний 0-20, 20-40 см-ын гүнээс дээж авч шилжлүүллээ.


Бэлчээрийн ургамлын бүтээмж болон сэргэж чадавхийг тодорхойлох гол үзүүлэлт болох хөрсний ус шингээх чадвар, хөрсний чийг хадгалах чадвар зэрэг нэмэлт үзүүлэлтээр үнэлсэн болно.

Хээрийн судалгааны дүнд үндэслэн БАХ-ийн бэлчээр ерөнхийдөө дараахь 3 үндсэн экологийн бүлгүүд (ЭЧБ) болон төлөв байдлын түвшин, сэргэх чадавхиар тус тус ангилж байна. Үүнд:

1. Голын татмын Алаг өвс-үетэнт нугын бэлчээр, Үетэн багассан төлөв байдал (СЧ III)
2. Шавранцар хөрстэй уулын хажуу, бэлийн Алаг өвс-жижиг дэгнүүлт үетэнт уулын хээрийн бэлчээр, Зонхилогч ургамал өөрчлөгдсөн төлөв байдал (СЧ III)
3. Шавранцар хөрстэй уулын хажуугийн Сөөгөн боролзгоно бүхий Улалж-үетэн-баялаг алаг өвст нугын хээрийн бэлчээр Хуурайшсан төлөв байдал(СЧ II).

Аргол БАХ-ийн нутагт дээр дурьдсан экологийн чадавхийн 3 бүлэгт хамрагдах бүлгүүд зонхилох бөгөөд зонхилох үетэн ургамлын бүрхэц шингэрсэн, багаас дунд зэрэг өөрчлөгдсөн төлөв байдалд байна. Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдлын загвараас үзэхэд малын тоо толгойг

даацад нь тохируулж бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлд энэхүү бэлчээр сэргэж сайжрах бүрэн боломж байна.



Аргол БАХ-ийн бэлчээрийн хөрс нь ерөнхийдөө үржил шимтэй сайтай, ургамлын бүлгэмдэлд тодорхой өөрчлөлт орсон, малын тоо толгойг бэлчээрийн даацыг тохируулж чадвал байгалийн аясаар нөхөн сэргэх боломжтой.

2022 оны байдлаар Аргол БАХ-ийн бэлчээрийн даац 15000 толгой хонин толгойтой. Цаашид Арголын БАХ-ын малын тоо толгой нэмэгдвэл бэлчээр ихээхэн доройтож, халцгай газрын хэмжээ нэмэгдэж, хөрсөн дэх нүүрсхүчлийн хийн ялгаралт үүсэх магадлалтай. Иймд Аргол БАХ-ийн малын тоо толгойг бэлчээрийн даацад нь тааруулах шаардлагатай байна.

## ДҮГНЭЛТ

Малын тоо толгойн албан татварын тухай хууль хэрэгжиж эхэлсэн нь бэлчээрийн нөөцийг онцгойлон анхаарч байгаль орчноо хамгаалахад чухал дэвшилттэй алхам болсон гэж хэлж болно. Гол асуудал бол мал сүргийн хяналтгүй өсөлт болон, ийм сөрөг үйл явцыг хянах орон нутгийн засаг захиргааны чадавх сул байгаагаас үүдэлтэй бэлчээрийн доройтлыг бууруулах зэрэг орон нутагт тулгамдаж буй асуудал, нэн тэргүүний хэрэгцээнд тэрхүү санхүүгийн эх үүсвэрийг ашиглах явдал юм. GLEAMI, RECSOIL зэрэг хэрэгслийг ашиглах нь МТТАТ-ын хэрэгжилтийн үр дүнд бий болсон өөрчлөлтийг хянах, бэлчээрийн дарамтыг бууруулах, сонирхогч талууд, түүний дотор татвар төлөгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хэрэв малын тоо толгойн албан татварын тухай хуулийн үзүүлэх нөлөөг илүү сайжруулна гэвэл түүнийг стратегийн үндсэн чиглэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь доор дурдсан зарим асуудлыг хамарч болох юм. Энэ асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй гарц бол малын тоо толгойн татварын орлогын хуваарилалтыг оновчтой болгох явдал юм. Энэ хөрөнгийг зөвхөн үйл ажиллагааны эрэмбээр хуваарилахын оронд малчдад зориулсан сургалтын хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх нь илүү ашигтай арга байж болох юм. Энэхүү сургалт нь зах зээлийн эрэлт хэрэгцээ, түүнд зохицож ажиллах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эцсийн дүндээ тогтвортой, ашигтай мал аж ахуйн менежментийн туршлагыг сурталчлах төрөл бүрийн үйл ажиллагааг хамарч болно.

GLEAMi-ийн туршилтаас дараах гол дүгнэлт гаргаж байна. Үүнд:

Малын тоо толгойн өөрчлөлтөд үндэслэн хүлэмжийн хийн ялгаралтыг тооцоходоо GLEAM (Дэлхийн мал амьтны хүрээлэн буй орчны үнэлгээний загвар) загварыг ашигласнаар малын тоо толгойн болон хүлэмжийн хийн ялгарал хооронд шууд хамааралтай нь харагдаж байна. Мал аж ахуйгаас ялгарах хүлэмжийн хийг тооцоолоход зориулагдсан хэрэгсэл болох GLEAM нь төрөл бүрийн мал, ялангуяа хивэгч малын тэжээл боловсруулах явцад үүссэн метаны ялгарлыг бууруулах тооцооллын хэрэглүүр болохын хувьд малын тоог хэрхэн удирдах боломжийг давхар харуулж байна. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүчин чармайлтын хүрээнд мал аж ахуйтай холбоотой асуудлыг илрүүлж өгснөөр мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах тогтвортой туршлагыг эрэлхийлж буй бодлого боловсруулагчид, тариаланчид, судлаачдад хэрэгцээтэй мэдээллийг энэхүү хэрэглүүр гаргаж өгч чадах юм.

○ Бусад хувилбаруудтай харьцуулахад малын тоог жилд 6 хувиар цөөлөх нь одоогийн тэжээлийн горимд хүлэмжийн хийн ялгаралтыг тасралтгүй бууруулж, хамгийн бага түвшинд хүргэх боломжтой харагдаж байна.

○ Бэлчээрийн мал аж ахуйн системд GLEAMi-г нэвтрүүлэх боломжтой боловч GLEAMi-ийн үзүүлэлтүүдийг Монголын нөхцөлд цаашид судалж, ургамалжилтын богино хугацаа, байгалийн бэлчээрийн менежментэд тулгуурлан зохицуулалт хийх хэрэгцээг тодорхойлох шаардлагатай байна.

○ GLEAMi олон улсын багтай хийсэн хэлэлцүүлгээс үзэхэд үндсэн тэжээлээр хангах, программ хангамжийн хүртээмжтэй холбоотой зарим нэг үл нийцэл байгаа ба түүнийг зассанаар уг хэрэгслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

○ GLEAMi-ийн санал болгож буй төрөл бүрийн тэжээлийн хэмжээ нь Монголын бэлчээрийн малын менежментэд төдийлөн тохирохгүй байна. Монгол орны зуны эхэн сараас намрын дунд үе, ургамал ургалтын хугацаа богино тул хараахан нийцэхгүй байна. Эрдэмтдийн судалгаагаар 6-р сарын 10-аас 9-р сарын эхний 10 хоног хүртэл зун үргэлжилдэг зун бол бэлчээрийн ногоон ургамлаас нүүрс хүчлийн хий ялгарах ганц улирал юм. Зун эхлэхээс өмнө бэлчээрийн бүхэл бүтэн бэлчээрийн тэжээлийн нөөц нь фотосинтезийн үйл ажиллагаа огт байхгүй бүх ургамал хатсан байдаг. Зарим үнэрт болон мал иддэггүй ургамал дутуу хагдсарсан байдалд ордог. Ийнхүү ХХЯ ялгарах хамгийн идэвхтэй үе 3 сар гаруй буюу 100 хүрэхтэй үгүйтэй хоног үргэлжилдэг

## RECISOIL



RECSOIL загвар хүснэгтэд байгаа хөрсний шинж чанарын үзүүлэлтүүдээс Монгол улсад тариалангийн газрын хувьд хөрсний pH, N,P,K, Electrical Conductivity, Ca, Mg зэрэг химийн шинж чанарын өгөгдөл хангалттай байгаа. Энэ өгөгдөл нь ГЗБГЗЗГ, Газар зүй - геоэкологийн хүрээлэнгийн хөрсний лаборатори, ХААИС-ийн хөрсний лабораторийн мэдээллийн санд байдаг. Харин хөрсний хатуулаг, ус нэвтрүүлэлт зэрэг физик үзүүлэлтийн өгөгдөл нэгдсэн байдлаар байхгүй байна.

Бэлчээрийн хувьд 2005-2010 оны хооронд бэлчээрийн төлөв байдал чанарын хянан баталгааны тайланд ялзмаг, азот, фосфор, кали, давсжилт зэрэг үзүүлэлтүүд сум тус бүрд 4-6 цэгийн өгөгдөл байгаа. Харин физик шинж чанарын үзүүлэлтүүд нэгдсэн байдлаар харахан байхгүй байна. Энэ өгөгдөл тухайн чиглэлээр судалгаа хийдэг төсөл, хөтөлбөр судлаачдад байх боломжтой. Гэхдээ нэгтгэж цуглуулах нь бэрхшээлтэй асуудал юм.

Улсын хэмжээнд нэгдсэн байдлаар RECSOIL загварын мэдээллийн сан бүрдүүлэхийн тулд энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран үндэсний хэмжээний семинар зохион байгуулах хэрэгтэй. Үүний үр дүнд хаана ямар өгөгдөл байгаа нь тодорхой болно. Үүний дараа мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг ажиллуулж мэдээллийг нэгтгэж RECSOIL мэдээллийн сан бий болох боломжтой. Харин хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүд одоогийн байдлаар байгууллагууд дээр мэдээллийн сан бүрдээгүй бөгөөд RECSOIL загварт оруулахад учир дутагдалтай.

## ЗӨВЛӨМЖ

### Холбогдох яам, агентлагт:

- Бэлчээрийн орон зайн ба тэжээлийн нөөцийн ашиглалт, мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежментэд хэмжигдэхүйц ахиц гаргахад орон нутгийн чадавхыг МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтээр дэмжих зорилгоор хүрсэн үр дүнд төлөвлөгөөт үнэлгээ хийж байх;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтын дагуу<sup>17</sup> холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнд хийх үнэлгээг СЯ, ХХААХҮЯ, Татварын ерөнхий газар дангаараа болон хамтран гүйцэтгэх,
- МТТАТ-ын орлогыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх журам, санал эрэмбэлэх аргачлал хэр оновчтой эсэхийг үнэлэх;
- Төсвийн тухай хууль, МТТАТ-ын тухай хуульд заасан 12 үндсэн үйл ажиллагаа тус бүрийг дотор нь задлах, ингэснээр МТТАТ-ын орлогоор санхүүжүүлэх стратегийн болон тэргүүлэх арга хэмжээг сонгоход орон нутгийн шийдвэр гаргагчдад дэмжлэг үзүүлэх;
- Дээрх шинэчилсэн баримт мэдээлэл, үнэлгээний дүн, дүгнэлтийг үндэслэн хуулийн хэрэгжилтийг сайжруулах, татвар төлөгчдөд үзүүлэх хөнгөлөлтийг тусгасан нэмэлт өөрчлөлтийг МТТАТ-ын тухай хуульд оруулах;

<sup>17</sup> <https://legalinfo.mn/mn/detail/11119>



- МТТАТ-ын орлогын зарцуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, үр нөлөөг нь үнэлэхийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох, тогтмолжуулах нь нэн чухал юм. Энэхүү тогтолцоогоор татварын орлогын зарцуулалтад хяналт тавьж, хүрсэн үр дүнг хэмжих ёстой. Түүнчлэн шаардлагатай гэж үзвэл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
  - Нэмэлт өөрчлөлтөд дараах асуудлыг тусгаж болох юм. Үүнд:
    - а) МТТАТ-ын орлогыг төлөхийг зогсоох өөрчлөлтийг Орон нутгийн хөгжлийн санд журамд оруулах;
    - б) холбогдох хууль, журамд заасан үйл ажиллагааг МТТАТ-ын орлогоор санхүүжүүлэх эх үүсвэрээр хангах тусгай сан байгуулах;
    - в) тавиул малд ногдуулах татварын хэмжээг тусад нь тогтоох;
    - г) бусад хуулиар тогтоосон мал өмчлөгчөөс болон улсын ба орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хориглох;
  - Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх
    - а) Малын тоо толгойн албан татварын хуульд заасан арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөний биелэлтийг хангах;
    - б) МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн тогтолцооны үнэлгээний хүрээнд туршсан CLEAMi, RECsoil загварыг хүлэмжийн хийн ялгарлын хяналтад ашиглах;
    - в) Малын бууц, шивхийг компостжуулж, органик үйлдвэрлэлд шим бордоо болгон хэрэглэх.
  - Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх
    - а) Малын тоо толгойн албан татварын хуульд заасан арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөний биелэлтийг хангах;
    - б) МТТАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн тогтолцооны үнэлгээний хүрээнд туршсан CLEAMi, RECsoil загварыг хүлэмжийн хийн ялгарлын хяналтад ашиглах;
    - в) Малын бууц, шивхийг компостжуулж, органик үйлдвэрлэлд шим бордоо болгон хэрэглэх.

### **Орон нутгийн өөрөө удирдах ба засаг захиргаа, татвар төлөгчдөд:**

- Бэлчээрийн талхагдал нэмэгдэн ургамалжилт, тэжээлийн нөөц, тэжээллэг чанар доройтож байгаа суурин дээр уур амьсгалын сөрөг өөрчлөлт, байнга нэмэгдэж буй хүлэмжийн хийн ялгарлын талаар мал аж ахуй эрхлэгчид, нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтны ойлголтыг гүнзгийрүүлэх онолын ба техникийн арга барилыг шинэ шатанд гаргах;
- Татварын тэгш байдал, хэрэгжилтийг хангах зарчмууд (өмч - адил орлогоос адил татвар), (үр ашигтай байх - хэрэгжүүлэхэд хялбар), (тодорхой байх - илүү өргөн хүрээтэй), (шударга - татвараас зайлсхийх боломжгүй), (уян хатан - татвар төлөгчдийн чадавхыг, харгалзах) сайжруулах болон идэвхжүүлэх (хариуцлагатай нүүдэлчдийн стандартын сургалт, бусад арга хэмжээ)-ыг орон нутагт тууштай хэрэгжүүлэх;
- МТТАТ-ын орлогыг хариуцлагатай нүүдэлчдийн ёс зүйн дүрмийг сумандаа хэрэгжүүлэхэд зарцуулах, ингэснээр найдвартай худалдан авагчдад түүхий эд, бүтээгдэхүүнээ ахиу үнээр борлуулах, бэлчээрийн доройтлыг бууруулах, малаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах, хувийн хэвшлийн оролцоог сайжруулах боломжийг бүрдүүлэх,

- Улсын хэмжээнд малын тоо толгойн албан татварын орлого сум бүрт буурч байгаатай холбогдуулан энэ байдлаас гарах арга зам, зохицуулалтыг сум бүр эрэлхийлэх, бодитой ажил хэрэг болгох,
- Малын тоог ухаалаг зохицуулж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг малчдын оролцоотой байгууллага, мал аж ахуйн бизнесийн түншүүдийн зүгээс бууруулах үр дүнтэй, ирээдүйтэй дасан зохицох чадварыг бэхжүүлэх;
- Орон нутгийн бодлого, үндэсний дасан зохицох төлөвлөгөөний хүрээнд бэлчээр ашиглалт, мал аж ахуйн салбарт гарсан өөрчлөлт, эерэг нөлөөллийг нийтийн хүртээл болгох;
- Байгууллагууд болон оролцогч талуудаас уур амьсгалын сөрөг өөрчлөлт, хөгжлийн дарамтыг хамгийн боломжтой, үр дүнтэй аргаар даван туулах чадавхыг бэхжүүлэх, малын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад талуудын оролцоог дэмжих;

### **GLEAMi болон Recsoil-ийг нэвтрүүлэх**

Уур амьсгалын өөрчлөлт нь биологийн олон янз байдал, мал, хүн амын газарзүйн тархцын өөрчлөлтийг үүсгэж, өвчин тархах болно гэдгийг судлаачид сэрэмжлүүлэг болгон тэмдэглэж байна.

- Бэлчээр ашиглалтын ачааллыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, үр нөлөөг ойлгохын тулд Монгол улсын нөхцөл байдалд GLEAMi болон Recsoil-ийн өргөтгөсөн туршилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд НҮБ-ын ХХААБ зэрэг байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй. Мал аж ахуйгаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаруулалтыг бэлчээрийн мал аж ахуйн нэгжүүдэд тодорхойлох хэрэгтэй.
- Орон нутгийн төрийн албан хаагчдыг орчин үеийн арга хэрэгсэл болох GLEAMi, RECSOIL ашиглан хүлэмжийн хийг тооцоолох аргачлалд сургах.

**ХАВСРАЛТ 1. WORK PLAN**

Үр дүн	№	Үр дүн	04-р сар				05-р сар				06-р сар				07-р сар				08-р сар				09-р сар			
			1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4
